



# ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



## ГЭМТ ХЭРЭГ - 2014





**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

**ГЭМТ ХЭРЭГ, ШҮҮХИЙН СТАТИСТИК-2014**

**УЛААНБААТАР  
2015 он**

Санал, хүсэлт байвал доорхи хаягаар холбоо барина уу.

Үндэсний Статистикийн Хороо  
Засгийн газрын III байр  
Бага тойруу -44, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар -11, Монгол улс  
Утас : (976-51)-261563; 262325  
Факс : (976-11)-324518  
Web хуудас : [www.nso.mn](http://www.nso.mn), [www.1212.mn](http://www.1212.mn)  
E-Mail : [international@nso.mn](mailto:international@nso.mn); [nso\\_hansg@nso.mn](mailto:nso_hansg@nso.mn)

Үндэсний Статистикийн Хорооноос эрхлэн гаргав.  
Улаанбаатар хот, 2015 он

# ГАРЧИГ

<b>ГЭМТ ХЭРГИЙН ЕРӨНХИЙ ДҮР ТӨРХ</b>	1
<b>1. УДИРТГАЛ</b>	4
1.1 Гэмт хэргийн тухай ойлголт	4
1.2 Гэмт хэргийн мэдээллийн үүсэл, эх үүсвэр	7
<b>2. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ</b>	8
2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн илрүүлэлт	9
2.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн төрлөөр	14
2.3 Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал	31
2.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг хугацаа, газар	33
2.5 Гэмт хэрэг үйлдэгчид	37
<b>3. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ</b>	41
3.1 Гэмт хэргийн улмаас хохирсон байгууллага, иргэн	41
3.2 Гэр бүлийн хүчирхийлэл бол орчин цагийн боолчлол	46
3.3 Гэмт хэргийн улмаас хохирсон байгууллага	49
3.4 Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан иргэд	50
3.5 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт	54
3.6 Эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан	56
<b>4. ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРЭГ</b>	56
4.1 Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг	56
4.2 Шүүхээр шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргаан	60
4.3 Захиргааны зөрчил	61
	64
<b>5. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ</b>	65
<b>6. ОЛОН УЛСЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ, БАЙДЛААС</b>	66
<b>7. ДҮГНЭЛТ</b>	68
<b>8. САНАЛ, ЗӨВЛӨМЖ</b>	72

## БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ДҮР ТӨРХ (2014 оны байдлаар)

- Бүртгэгдсэн 10 гэмт хэрэг тутмын
  - 6 нь нийслэлд
  - 4 нь аймаг, орон нутаг
  - 2 нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг
  - 1 нь эмэгтэйчүүд оролцсон хэрэг
- Бүртгэгдсэн 10 хэрэг тутмын
  - 5 нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
  - 3 нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байна.
- Өмчлөх эрхийн эсрэг 10 хэрэг тутмын
  - 7 нь бусдын эд хөрөнгийг хулгайлах
  - 5 нь хувийн өмчийг хулгайлах
  - 2 нь бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах
- Халаасны хулгайн хэргийн 96.4 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.
- Нийслэлд бүртгэгдсэн халаасны хулгайн 10 хэрэг тутмын
  - 4 нь Сүхбаатар дүүрэгт
  - 2 нь Баянгол дүүрэгт
  - 2 нь Баянзүрх дүүрэгт
- Хүний амь,бие эрүүл мэндийн эсрэг 10 хэрэг тутмын
  - 9 нь бусдын бие махбодид гэмтэл учруулах
  - 6 нь нийслэлд
- Нийслэлд бүртгэгдсэн хүний амь бие эрүүл мэндийн эсрэг 10 хэрэг тутмын
  - 2 нь Сонгинохайрхан дүүрэгт
  - 2 нь Баянзүрх дүүрэгт
- Хүүхэд, гэр бүл, ёс суртахууны эсрэг 10 хэрэг тутмын
  - 8 нь хүчингийн хэрэг байна.
- Гэмт хэргийн илрүүлэлт
  - хамгийн багатай аймаг, дүүрэг- Завхан аймаг (41.5%), Баянзүрх дүүрэг (48.2 %) -т,
  - хамгийн өндөртэй аймаг, дүүрэг- Сүхбаатар аймаг (80.0%), Налайх дүүрэг (76.4 %) байна.
- Бүртгэгдсэн 10 гэмт хэрэг тутмын
  - 8 нь ажлын цагаар
  - 2 нь амралтын цагаар
  - 4 нь 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн байна.
- Гудамж, талбайд үйлдэгдсэн 10 хэрэг тутмын
  - 4 нь гэр хорооллын гудамжинд үйлдэгджээ.
- Гэр орон сууцанд үйлдэгдсэн 10 хэрэг тутмын
  - 4 нь гэрт
  - 2 нь орон сууцны байранд
  - 2 нь хувийн байшинд
- Хэрэгт холбогдсон 10 хүн тутмын
  - 5 нь ажилгүй иргэд

- 5 нь 18-29 насны залуучууд
- 4 нь бүрэн дунд боловсролтой
- 2 нь эмэгтэй
- 3 нь согтуугаар үйлдсэн


 Гэмт хэргийн улмаас Монгол Улсын 10 000 хүн тутмаас

2013 онд


- 85 иргэн хохирсны
- 35 нь эмэгтэй
- 5 нь 18 хүртэлх насны хүүхэд

2014 онд


- 93 иргэн хохирсны
- 36 нь эмэгтэй
- 5 нь 18 хүртэлх насны хүүхэд байна.

 Гэмт хэргийн улмаас хохирсон 10 хүн тутмын

- 5 нь 18-34 насны залуучууд
- 6 нь эрэгтэйчүүд
- 3 ажилгүй иргэд байна.

 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 10 хүн тутмын

- 8 нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн
- 6 нь тухайн хүчирхийлэгчийн эхнэр байна.

 Гэмт хэргийн улмаас хохирсон 100 хүн тутмын


- 4 нь нас барсан
- 41 нь гэмтсэн хүн байна.

 Гэмт хэргийн улмаас нас барсан 10 хүн тутмын


- 5 нь тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас
- 3 нь эмэгтэй хүн

 Гэмт хэргийн улмаас нас барсан 10 хүүхэд тутмын

- 5 нь авто ослын улмаас

 Гэмт хэргийн улмаас гэмтсэн 10 хүн тутмын

- 7 нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас
- 1 нь Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг

 Гэмтсэн 100 хүн тутмын

- 8 нь хүнд гэмтэл авсан
- 15 нь хүндэвтэр гэмтэл авсан байна.

## ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, ОНООР

	нэгж	2013 он	2014 он	Өөрчлөлт
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг</b>	<b>тоо</b>	<b>25 362</b>	<b>27 318</b>	<b>↑</b>
хөнгөн	тоо	11 648	13 057	↑
хүндэвтэр	тоо	11 514	11 951	↑
хүнд	тоо	1 766	1 781	↑
онц хүнд	тоо	434	529	↑
Үндэсний аюулгүй байдлын эсрэг	тоо	54	45	↓
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	тоо	8 156	8 697	↑
Хүний эрх, эрх чөлөө, алдар хүндийн эсрэг	тоо	55	49	↓
Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг	тоо	425	397	↓
Иргэдийн улс төрийн болон бусад эрх чөлөөний эсрэг	тоо	124	144	↑
Өмчлөх эрхийн эсрэг	тоо	11 118	12 551	↑
Аж ахуйн эсрэг	тоо	234	426	↑
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	тоо	1 894	1 750	↓
Хүн амын эрүүл мэндийн эсрэг	тоо	318	303	↓
Байгаль хамгаалах журмын эсрэг	тоо	337	287	↓
ТХХАБАЖ-ын эсрэг	тоо	2148	2 143	↓
Шүүн таслах ажиллагааны эсрэг	тоо	104	118	↑
Албан тушаалын гэмт хэрэг	тоо	106	135	↑
Цэргийн албаны эсрэг	тоо	10	11	↑
Хохирогч иргэн	тоо	25 015	27 475	↑
Нас барсан	тоо	949	1 078	↑
Гэмтсэн	тоо	9 797	11 281	↑
Хохирогч байгууллага	тоо	157	118	↓
Учирсан хохирол	тэрбум.төг	159.0	148.3	↓
Нөхөн төлүүлэлт	тэрбум.төг	111.3	43.7	↓
Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг	тоо	6 169	6 375	↑
Шүүхээр ял шийтгүүлсэн хүн	тоо	8 042	8 178	↑
Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргаан	тоо	1 080	1 377	↑
Ажлаас буруу шилжүүлсэн	тоо	36	28	↓
Ажлаас үндэслэлгүй халагдсан	тоо	725	742	↑
Цалин хөлсний маргаан	тоо	206	475	↑
Шүүхийн шийдвэрийн нөхөн төлүүлэлт	сая.төг			
Эрүүгийн хэргийн шийдвэртэй	сая.төг	4 863.0	7 059.8	↑
Иргэний хэргийн шийдвэртэй	сая.төг	88 988.8	270 205.3	↑
Захиргааны хэргийн шийдвэртэй	сая.төг	99.2	60.8	↓
Бусад хэргийн шийдвэртэй	сая.төг	413 535.8	55 735.5	↓

## 1. УДИРТГАЛ

### 1.1 ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ.

Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж тодорхойлсон байна. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна. Тухайлбал:

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг;
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг;
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг;
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг;
- Бусад гэмт хэрэг.

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны суурин хүн амын тоонд харьцуулж тооцно.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг **яллагдагч** гэнэ.

Гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдож, ял шийтгэл эдэлж байгаа болон ял шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй этгээдийг **ял шийтгэгдсэн хүн** гэнэ.



## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

№	Ойлголт	Тодорхойлолт
1	Гэмт хэрэг	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.
2	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	<b>Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт</b> хүнийг санаатай алах, эх нь нярай хүүхдээ алах, санаа сэтгэл нь хүчтэй цочирдон давчдсан үед бусдыг санаатай алах, бусдыг болгоомжгүй алах, бусдыг амиа хорлоход хүргэх, бусдын бие махбодид хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл учруулах, тарчлаах зүйл ангиудыг хамааруулна.
3	Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг	<b>Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэгт</b> хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс зөвхөн бусдын биед учруулсан хохирлыг санаатай буюу болгоомжгүй байдлаар хүнд, хүндэвтэр, хөнгөн хэлбэрээр учруулсан гэмтлийг хамааруулна.
4	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	<b>Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт</b> танхайрах, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодис буюу хордуулах цацраг идэвхт тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх, уулгалан довтолох, зандалчлах, терроризм, аюулгүй ажиллагааны журам зөрчих, нийтийн эмх замбараагүй байдал буй болгох зүйл ангиудыг хамааруулна.
5	Өмчлөх эрхийн эсрэг	<b>Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт</b> бусдын эд хөрөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх, залилан мэхэлж авах, завших, үрэгдүүлэх, бусдын эд хөрөнгөнд болгоомжгүйгээр хохирол учруулах, бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх, өмчлөгчийн эрхийг зөрчих зэрэг зүйл ангиудыг хамааруулна.
6	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	<b>Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт</b> Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих, зам тээврийн ослын үед үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, согтуурсан буюу мансуурсан хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах, жолоогоо бусдад шилжүүлэх, төмөр зам, усан болон агаарын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон техник ашиглалтын журам зөрчих, агаарын хөлөг авч зугтаах, Олон улсын нислэгийн журам зөрчих, тээврийн хэрэгсэл, зам харилцааны төхөөрөмжийг эвдэх, гэмтээх зэрэг зүйл ангиудыг хамааруулна.
7	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	<b>Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэгт</b> хүн хулгайлах, хүнийг хууль бусаар хорих, доромжлох, гүтгэх, хүн барьцаалах, хүн худалдаалах зэрэг зүйл ангиудыг хамааруулна.

8	<b>Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг</b>	Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах, хүүхэд солих, хууль бусаар үрчлэх, хүүхэд хаях, төөрүүлэх, асран хамгаалах үүргээ урвуулах, сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэгт ажилдаа хайнга хандах, эцэг, эхь эхнэр, нөхөр төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх, хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх, 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх, садар самууныг сурталчлах, бие үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, хүчиндэх, эмэгтэй хүнийг тулган шаардаж үр хөндүүлэх, эмнэлгийн бус нөхцөлд үр хөндөх, булш сүйтгэх зэрэг гэмт үйлдлүүдийг хамааруулна.
9	<b>Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг</b>	Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх, сонгууль болон ард нийтийн санал асуулгад хууль бусаар илүү санал өгөх, сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах, жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчих, гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж зөрчих, иргэнийг үзэл бодлоор нь мөрдөн мөшгих, иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих, хувь хүний нууцыг задруулах, иргэний орон байрны халдашгүй байдлыг зөрчих, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам зөрчих, сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих, шинэ бүтээл бүтээгдхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигчийн эрхийг зөрчих, хүний шашин шүтэх, эс шүтэх эрхийг зөрчих, шүтэж байгаа шашнаар нь хүнийг ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгих, шашны харгис үзэл номлол сурталчлах, тараах зэрэг гэмт үйлдлүүдийг багтаана.
10	<b>Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг</b>	Агаар бохирдуулах, ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих, газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчих, байгаль орчныг бохирдуулах, химийн гаралтай хорт бодис, үйлдвэрлэлийн хог хаягдал цэвэрлэх, тээвэрлэх, булшлах журам зөрчих, газрын хөрс, усыг бохирдуулах, усны тухай хууль тогтоомж зөрчих, ургамлын өвчин, хортон амьтантай тэмцэх талаар тогтоосон журам зөрчих, байгалийн объектыг санаатай эвдэх, гэмтээх, устгах, ойн тухай хууль тогтоомж зөрчих, байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчих, ой, хээрийн түймэр тавих, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчих зэрэг үйлдлүүдийг хамруулна.

11	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хурааж авах, мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх газар зохион байгуулах, хууль бусаар эмчлэх, хууль бусаар эм, эмнэлэгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх, тахал болон гоц халдварт бусад өвчинтэй тэмцэх журам зөрчих, хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах зэрэг үйлдлүүд орно.
12	Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	Банк, хоршоо болон банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчих, банкны үйл ажиллагаанд албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж оролцох, үнэт цаас, даатгал, аудит, эрдэнэсийн сангийн тухай хууль, тогтоомж зөрчих, хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх нэрээр халхавчлан хууль бус үйл ажиллагаа явуулах, санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны нууцыг хууль бусаар олж авах, задруулах, санаатайгаар төлбөрийн чадваргүй болгох, дампууруулах, татвар төлөхөөс зайлсхийх, мөнгө угаах, дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж арилжаанд оролцох, үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах, барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашиглах, хэрэглэгчийг хуурч, мэхлэх, төөрөгдүүлэх, хууль бусаар шан харамж авах, гологдол буюу чанар муутай бүтээгдэхүүн худалдах, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, согтууруулах ундааг хориглосон зүйлээр бэлтгэх, чанар муутай барилга бариулах, ашиглалтанд оруулах, эд зүйлсийг хууль бусаар хил нэвтрүүлэх, мөнгөн тэмдэгт, үнэт цаас, онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдэх, ашиглах, борлуулах зэрэг үйлдлүүд багтана.

## 1.2 Гэмт хэргийн статистикийн мэдээллийн үүсэл, эх үүсвэр

НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодисын газар 1950 онд байгуулагдсанаар гэмт хэргийн статистик мэдээллийг олон улсын түвшинд цуглуулж эхэлсэн байна.

1933 онд батлагдсан Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд Цагдаагийн төв байгууллагын харьяанд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах асуудлаар шинжилгээ, судалгаа явуулах үүрэг бүхий байгууллага байж

болно, мөн хуулийн 28 дугаар зүйлд Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд туслах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан байгуулж, ашиглана гэж заасан нь өнөөгийн Мэдээлэл, судалгааны төвийн эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн түүхтэй.

Манай улсад гэмт хэргийн мэдээлэл 1980-аад оноос улам өргөжин мэдээлэл технологийн дэвшилтэт арга технологийг ашиглах болж, улмаар гэмт хэргийн салбарын мэдээллийн санг бүрдүүлж эхэлсэн байна.

Гэмт хэргийн мэдээллийг 1965 он хүртэл албан ёсоор нийтэд мэдээлдэггүй байсан нь гэмт хэргийн тухай бодит мэдээллийг олон түмнээс нууцалж байсантай холбоотой юм.

1993 онд батлагдсан Шүүхийн тухай хуулийн 55 дугаар зүйлд “ Улсын Дээд шүүхийн дэргэд шүүхээс хууль хэрэглэх, тайлбарлахад хууль зүйн онолын асуудлаар зөвлөмж өгөх, шүүхийн статистик тоон мэдээлэл, практикийг нэгтгэн дүгнэж санал гаргах үүрэг бүхий шүүхийн судалгааны төв ажиллана” гэж заасны дагуу Шүүхийн судалгааны төв байгуулагдан ажилласнаар Монгол улсад шүүхийн статистикийн үндэс суурь тавигдсан түүхтэй.

Олон улсын түвшинд гэмт хэргийн статистик нь хоёр эх үүсвэрээс бүрддэг байна. Үүнд:

1. Гэмт хэрэг, шүүхийн албан ёсны мэдээлэл
2. Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн судалгаа

Манай орны хувьд гэмт хэргийн статистикийн мэдээллийн гол эх үүсвэр нь одоогоор Цагдаагийн Ерөнхий Газрын сар бүрийн мэдээ, Улсын Дээд Шүүхийн хагас, бүтэн жилийн тайлан байна. Эдгээр мэдээллийн эх үүсвэрт үндэслэж гэмт хэрэг, гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, холбогдогч, хохирогч, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, ял шийтгэгдсэн хүний тоо, шүүхээр шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргаан зэрэг үзүүлэлтийг сар, улирал, жилийн бюллетень, танилцуулга, эмхэтгэлд тусган нийтэд хүргэж байна.



## 2.ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Гэмт хэргийн гаралт, түүний хандлага, бүтэц, тархалт, гэмт хэрэг үйлдэгчдийн байдалд нөлөөлдөг үндсэн 3 хүчин зүйл байдаг:

- Эдийн засгийн хүчин зүйл
- Нийгмийн орчны хүчин зүйл
- Гэр бүлийн хүчин зүйл

Эдийн засгийн хүчин зүйлд санхүүгийн нөөцийн хомс байдал, ядуурал, боловсрол олж авах болон ажил эрхлэх боломж муу байх, орон сууцны нөхцөл муу байх, байгууллагын хариуцлага зэрэг олон зүйлүүд багтаж байдаг.

Нийгмийн орчны хүчин зүйлд гэр бүлд үзүүлэх дэмжлэг бага байх, хүүхэд, хувь хүний төлөвшилд анхаарал бага тавих, иргэдийн чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх орчин, нөхцөл муу зэрэг олон зүйлүүд багтдаг.

Гэр бүлийн хүчин зүйлд дараах зүйлүүд ордог. Үүнд:

- Эцэг, эхийн үл нийцэх байдал, хоорондын зөрчил
- Эцэг эх гэмт хэрэг үйлдэх, хэрэгт холбогдох
- Бие биеэ үл хүндэтгэх, хариуцлага хүлээхгүй байх
- Хүүхэдтэй зүй бусаар харьцах, хүчирхийлэх, хайхрахгүй байх
- Гэр бүлийн хүчирхийлэл


## ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТАНД НӨЛӨӨЛДӨГ ХУЧИН ЗҮЙЛҮҮД




### 2.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙ ИЛРҮҮЛЭЛТ

Гэмт хэрэг бол өөрөө нийгмийн амьдралын сөрөг үр дагавар бөгөөд эдийн засаг доройтож ажилгүйдэл, ядуурал нэмэгдэхэд гэмт хэрэг ч бас нэмэгдэж байдаг.


Улсын хэмжээнд 2014 онд 27.3 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2000 оныхоос 3855 хэрэг буюу 16.4 хувь, 2005 оныхоос 9907 хэрэг буюу 56.9 хувь, 2007 оныхоос 6050 хэрэг буюу 28.4 хувь, 2013 оныхоос 1956 хэрэг буюу 7.7 хувиар нэмэгдсэн байна (Зураг 2.1.1).

**Зураг 2.1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, 1990-2014 он**

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо нэмэгдэж байгаа нь нэг талаас хэрэг бүртгэл сайжрах, сэжигтэн холбогдогч нь тогтоогдоогүй байсан хэрэг илрэх гэх мэт эерэг тал байгаа хэдий ч нөгөө талаас нийгмийн тогтворгүй байдал, амьжиргааны түвшний доройтол, ажилгүйдлээс шалтгаалж гэмт хэргийн гаралт нэмэгдсэнтэй холбоотой. Сүүлийн 24 жилийн хугацаанд хамгийн бага гэмт хэрэг бүртгэгдсэн жил 1990 он, хамгийн олон хэрэг бүртгэгдсэн жил 2014 он байна.

**Зураг 2.1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, сүүлийн 24 жилд**

Улсын хэмжээнд 2014 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 14.7 хувь нь Төвийн бүсэд, 11.1 хувь нь Хангайн бүсэд, 5.5 хувь нь Баруун бүсэд, 5.4 хувь нь Зүүн бүсэд, 62.8 хувь нь нийслэлд, 36.7 хувь нь аймгуудад, 0.4 хувь нь төмөр замын цагдаагийн хэлтэст, 0.1 хувь нь иргэний агаарын тээврийн салбар болон бусад газарт бүртгэгджээ.

**Зураг 2.1.3 Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүс, нийслэлээр, 2011-2014 он**

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 43.8 хувийг хүндэвтэр, 47.8 хувийг хөнгөн, 6.5 хувийг хүнд, 1.9 хувийг онц хүнд хэрэг эзэлж, 2013 оныхоос хөнгөн хэргийн эзлэх хувь 1.9 пункт, онц хүнд хэргийнх 0.2 пункт нэмэгдэж, хүнд хэргийнх 0.4 пункт, хүндэвтэр хэргийнх 1.7 пунктээр буурав.


**Хүснэгт 2.1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, ангиллаар, 2007-2014 он**

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг</b>	<b>21 268</b>	<b>20 704</b>	<b>20 373</b>	<b>19 825</b>	<b>19 197</b>	<b>22 089</b>	<b>25 362</b>	<b>27 318</b>
<b>Гэмт хэргийн ангиллаар</b>								
Хөнгөн	7 881	7 854	7 857	8 151	7 977	9 637	11 648	13057
Хүндэвтэр	9 786	10 165	10 006	9 219	8 889	10 041	11 514	11951
Хүнд	3 158	2 352	2 126	2 014	1 823	1 914	1 766	1781
Онц хүнд	443	333	384	441	508	497	434	529

Гэмт хэргийн өсөлт, бууралтыг 2013-2014 оны сар тус бүрээр авч үзэхэд, 2013 оны 1,4, 5,7,10, 12-р сар, 2014 оны 1, 3, 4, 9, 10, 12-р саруудад өссөн дүнтэй, бусад саруудад буурсан байна. Эндээс үзэхэд жил бүрийн 1, 4, 10, 12-р саруудад гэмт хэрэг тогтмол өсдөг байна (Зураг 2.1.2).



**Зураг 2.1.3 Гэмт хэргийн өсөлт, бууралт, өмнөх сартай харьцуулсан хувиар, 2012-2014 он**



Гэмт хэргийн илрүүлэлт гэдэг нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргээс гэмт хэрэг үйлдсэн эзнийг нь тогтоож ял сонгосон хэргийн хувийн жингээр тооцогддог чанарын үзүүлэлт юм.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 46.1 хувийг бүртгэгдэх үедээ сэжигтэн нь тогтоогдоогүй хэрэг эзэлж байгаа нь 2013 оныхоос 3.1 пунктээр өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 2013 оныхоос улсын дүнгээр 0.1 пунктээр нэмэгдэж, нийслэлд 1.2 пунктээр буурчээ ( Хүснэгт 2.1.2 ).

**Хүснэгт 2.1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, хэргийн илрүүлэлт, 2007-2014 он**


Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг</b>	<b>21 268</b>	<b>20 704</b>	<b>20 373</b>	<b>19 825</b>	<b>19 197</b>	<b>22 089</b>	<b>25 362</b>	<b>27 318</b>
Бүртгэгдэх үедээ сэжигтэн нь тогтоогдоогүй хэрэг	6 880	6 692	7 086	6 445	6 504	8 140	10 910	12 585
Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоосон хэрэг	1 956	2 231	3 890	3 859	3 999	4 585	6 382	7 370
Илрүүлэлтийн хувь	28.4	33.3	54.9	59.9	61.5	56.3	58.5	58.6

2014 оны байдлаар аймагт гэмт хэргийн илрүүлэлт Завхан, Дундговь аймгуудад хамгийн бага, Сүхбаатар, Сэлэнгэ аймгуудад хамгийн өндөр байна. Гэмт хэргийн




илрүүлэлт улсын дүнгээр 58.5 хувь, нийслэлд 55.3 хувь, аймгуудын хувьд 41.5-80.0 хувьтай байна.

**Зураг 2.1.4 Гэмт хэргийн илрүүлэлт, хувиар, 2014 он**




Гэмт хэргийн илрүүлэлт 2014 онд нийслэлд 1.2 пунктээр буурахад Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүдэд гэмт хэргийн илрүүлэлт 1.8-3.6 пунктээр буурсан нь голлон нөлөөлжээ. Бусад дүүргүүдэд гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдсэн байна.

**Зураг 2.1.5 Гэмт хэргийн илрүүлэлт, дүүргээр, хувиар, 2011-2014 он**



Улсын дунджаар 18 ба түүнээс дээш насны 10 000 хүн тутамд 2014 онд 140 гэмт хэрэг ногдож байгаа нь 1990 оныхоос 2.2 дахин, 2006 оныхоос 28 хэрэг буюу 25.0 хувь, 2013 оныхоос 7 хэрэг буюу 5.0 хувиар өссөн байна.

**Зураг 2.1.6 18 ба түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох гэмт хэрэг, 1990-2014 он**




Сүүлийн 24 жилд 18 ба түүнээс дээш насны 10 000 хүнд ноогдох гэмт хэрэг 1997 онд хамгийн их (193) байна. Улсын дунджаар 2014 онд 18 ба түүнээс дээш насны 10 000 хүн тутамд ногдох гэмт хэрэг 140 байгаа бөгөөд Говьсүмбэр(208) аймаг, Улаанбаатар (194) хотод улсын дунджаас дээгүүр байна.

## 2.2 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ТӨРЛӨӨР

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл 2014 онд нийт гэмт хэрэгт Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 45.9 хувь болж өмнөх оныхоос 2.1 пункт, Аж ахуйн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 1.6 хувь болж 0.7 пунктээр нэмэгдэж, харин Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 31.8 хувь болж 0.3 пункт, Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 7.8 хувь болж 0.6 пункт, Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 6.4 хувь болж 1.1 пунктээр буурсан байна.

**Зураг 2.2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2013-2014 он**




## Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2014 онд 8697 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 541 буюу 6.6 хувиар нэмэгджээ. Энэ төрлийн гэмт хэрэг 2010 он хүртэл жил дараалан өсч байснаа 2011 онд буурч, сүүлийн жилүүдэд эргээд нэмэгдэж байна.

### **Хүснэгт 2.2.1 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 2004-2014 он**

Хэргийн төрөл	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
<b>Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг</b>	<b>4 526</b>	<b>4 512</b>	<b>5 280</b>	<b>5 843</b>	<b>6 524</b>	<b>6 808</b>	<b>6 813</b>	<b>6 462</b>	<b>7 155</b>	<b>8 156</b>	<b>8 697</b>
Хүнийг санаатай алах	335	310	311	300	213	223	230	262	231	204	211
Бусдыг болгоомжгүй алах	19	16	15	14	23	16	15	21	14	21	27
Бусдын биед гэмтэл учруулах	2 846	2 991	3 584	4 614	5 319	5 770	5 821	5 838	6 546	7 564	8 132
Бусдыг амиа хорлоход хүргэх	1 293	1 167	1 340	888	945	764	727	314	324	323	288
Амиа хорлосон хүн	-	-	-	-	-	-	119	51	46	48	43
Золгүй явдлаас нас барсан	-	-	-	-	-	-	608	263	278	275	245
Бусад	33	28	30	27	24	35	20	27	40	44	39
<b>Дүнд харьцуулсан хувь</b>											
<b>Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Хүнийг санаатай алах	7.4	6.9	5.9	5.1	3.3	3.3	3.4	4.1	3.2	2.5	2.4
Бусдыг болгоомжгүй алах	0.4	0.4	0.3	0.2	0.4	0.2	0.2	0.3	0.2	0.3	0.3
Бусдын биед гэмтэл учруулах	62.9	66.3	67.9	79.0	81.5	84.8	85.4	90.3	91.5	92.7	93.5
Бусдыг амиа хорлоход хүргэх	28.6	25.9	25.4	15.2	14.5	11.2	10.7	4.9	4.5	3.9	3.3
Амиа хорлосон хүн	-	-	-	-	-	-	16.4	16.2	14.2	14.9	14.9
Золгүй явдлаас нас барсан	-	-	-	-	-	-	83.6	83.8	85.8	85.1	85.1
Бусад	0.7	0.6	0.6	0.5	0.4	0.5	0.3	0.4	0.6	0.6	0.4

### **Зураг 2.2.2 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 2004-2014 он**




Бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн 17.6 хувийг бүртгэгдэх үедээ сэжигтэн нь тогтоогдоогүй хэрэг эзэлж байгаа нь 2013 оныхоос 4.4 пунктээр нэмэгдсэн байна. Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн илрүүлэлт 2014 онд улсын хэмжээнд 85.2 хувь байгаа нь 2013 оныхоос 0.1 пунктээр нэмэгджээ.


Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 93.5 хувийг бусдын биед гэмтэл учруулах гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 0.8 пунктээр нэмэгджээ.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 58.7 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд Дархан-Уул (321), Төв (279), Сэлэнгэ (265), Хөвсгөл (227), Орхон (236), Өвөрхангай (186) аймагт энэ төрлийн гэмт хэргийн гаралт бусад аймгийнхаас их байна.


**Зураг 2.2.3 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг ба бусдын биед гэмтэл учруулах гэмт хэргийн харьцаа, 2004-2014 он**




Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 2.4 хувийг хүнийг санаатай алах гэмт хэрэг эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.1 пунктээр буурсан байна. Хүнийг санаатай алах хэргийн илрүүлэлт 2014 онд 95.5 хувьд хүрсэн нь өмнөх оныхоос 2.9 пунктээр нэмэгдсэн байна. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хүнийг санаатай алах гэмт хэрэг 1991 онд хамгийн бага, 2000 онд хамгийн олон бүртгэгдсэн байна.

**Зураг 2.2.4 Хүнийг санаатай алах гэмт хэрэг, 1991-2014 он**

Хүнийг санаатай алах хэрэг Ховд, Булган, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймагт буурсан хэдий ч Баянхонгор, Орхон, Хөвсгөл, Дархан-Уул, Дорноговь, Төв аймгуудад нэмэгдсэн байна (Зураг 2.2.4).

**Зураг 2.2.5 Хүнийг санаатай алах гэмт хэргийн гаралт өндөртэй аймаг, 2014 он**

**Зураг 2.2.6 Хүнийг санаатай алах гэмт хэрэг, сүүлийн 24 жилд**

Хүнийг болгоомжгүйгээр алах гэмт хэрэг 2014 онд 27 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 6-аар нэмэгджээ. Энэ хэргийн илрүүлэлт 100.0 хувь байна.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 58.7 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн гаралт Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдэд их байна. Амиа хорлосон хүн 2014 онд 43 болж өмнөх оныхоос 5 буюу 10.4 хувь, золгүй учралаар амь насаа алдсан хүн 245 болж, 30 буюу 10.9 хувиар буурсан байна.

2014 онд амиа хорлосон хүмүүсийн 97.7 хувь нь өөрийгөө боомилсон, золгүй явдлаас амь насаа алдсан хүмүүсийн 14.7 хувь нь өвчний улмаас, 7.8 хувь нь архинд гүн хордсоны улмаас, 4.9 хувь нь осгож хөлдсөний улмаас нас барсан байна. 2014 оны эцсийн байдлаар, нийт 288 хүн амиа хорлосон болон золгүй байдлаар нас баржээ. Эдгээр хүмүүсийн 0.7 хувь нь хүүхдүүд, 3.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Амиа хорлосон болон золгүй байдлаар нас барсан хүмүүсийн 19.8 хувь нь согтуугаар нас барсан байна.

### **Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг**


Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 2014 онд 12551 бүртгэгдэж, өмнөх оныхоос 1433 хэрэг буюу 12.9 хувиар өсөхөд энэ төрлийн гэмт хэргийн 67.1 хувийг эзэлж буй хулгайн хэрэг 540-өөр, халаасны хулгайн хэрэг 160-аар, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж, авах хэрэг 612-оор, авто тээврийн хэрэгслийн хулгай 114-өөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнд ордог дийлэнх төрлийн гэмт хэрэг сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай хэдий ч завших, үрэгдүүлэх хэрэг 8.9 хувиар буурсан байна (Хүснэгт 2.2.2.).

**Хүснэгт 2.2.2 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 2004-2014 он**

Хэргийн төрөл	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	10 138	8 896	8 847	10 865	9 489	8 853	7 944	7 232	9 023	11 118	12 551
Хулгай	7 861	6 683	6 657	7 927	6 609	6 376	5 777	5 276	6 266	7 884	8 424
Булаалт	328	327	418	703	354	167	143	137	179	227	245
Дээрэм	655	584	455	656	818	754	520	536	552	620	686
Залилан	697	678	669	816	866	801	764	688	1 098	1 231	1 843
Завших, үрэгдүүлэх	338	371	341	357	331	348	337	202	269	326	297

Хулгайн гэмт хэрэг 2014 онд 8424 бүртгэгдэж, 2013 оныхоос 540 хэрэг буюу 6.8 хувь, булаах гэмт хэрэг 18 хэрэг буюу 7.9 хувь, дээрэм 66 хэрэг буюу 10.6 хувь, залилан 612 хэрэг буюу 49.7 хувиар өссөн байна.


**Зураг 2.2.7 Хулгайн хэргийн бүтэц, төрлөөр, 2013-2014 он**

Иргэдийн өмчийг хулгайлах хэрэг 1991 оноос 2000 он хүртэлх хугацаанд өссөн бөгөөд 2004 оноос хойш буурч байгаад сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэг 1990 оноос 1993 онд эрс нэмэгдэж 9242-д хүрсэн нь сүүлийн 24 жилийн хугацаанд хамгийн их хулгай гарсан жил байжээ.




**Зураг 2.2.8 Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг, 2004-2014 он**



Малын хулгайн 1434 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 5.2 хувийг эзэлж, өмнөх оныхоос 0.5 пунктээр буурчээ.


**Зураг 2.2.9 Малын хулгайн гэмт хэрэг, 2005-2014 он**



2014 онд Төв(217), Хэнтий(170), Дорнод(122), Архангай(107), Хөвсгөл(103), Сэлэнгэ(90) аймгуудад хамгийн их гарсан бол Өмнөговь(7), Говь-Алтай(7) аймгуудад хамгийн бага малын хулгай бүртгэгдсэн байна.

**Зураг 2.2.10 Малын хулгайн гаралт ихтэй аймгууд, 2014 он**

Тээврийн хэрэгслийн хулгайн хэрэг 249 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн хэргийн 0.9 хувийг эзэлж, өмнөх оныхоос 114 хэрэг буюу 84.4 хувиар өссөн байна. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 58.3 хувь болж өмнөх оныхоос 0.2 пунктээр буурсан байна.


**Зураг 2.2.11 Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг, 2005-2014 он**

Хувийн өмч хулгайлах гэмт хэргийн 9.6 хувийг эзэлдэг халаасны хулгай тууштай буурахгүй байгаа бөгөөд 2014 онд энэ төрлийн гэмт хэрэг 586 бүртгэгдэж, өмнөх оныхоос 160 хэрэг буюу 37.6 хувиар өссөн байна. Халаасны хулгайн 96.4 хувь нь нийслэлд бүртгэгдсэн бөгөөд Сүхбаатар дүүрэгт 210 хэрэг буюу 37.2 хувь,

Баянзүрх дүүрэгт 137 буюу 24.2 хувь, Баянгол дүүрэгт 108 буюу 19.1 хувь нь бүртгэгджээ.

Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг 2014 онд 245 бүртгэгдэж, өмнөх оныхоос 18 хэрэг буюу 7.9 хувь, залилан мэхлэх хэрэг 1843 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 612 хэрэг буюу 49.7 хувиар нэмэгдэж, харин завших, үрэгдүүлэх гэмт хэрэг 297 болж, өмнөх оныхоос 29 хэрэг буюу 8.9 хувиар буурчээ.


**Зураг 2.2.12 Бусдын эд хөрөнгийг булаах, залилан мэхэлж авах, завших, үрэгдүүлэх гэмт хэргийн гаралт, 2005-2014 он**




Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 2014 онд 686 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 66 хэрэг буюу 10.6 хувиар нэмэгдсэн байна.


Дээрмийн хэрэг 2003 онд 825 бүртгэгдэж байсан нь 1991 оноос хойшхи 24 жилийн хугацаанд хамгийн өндөр үзүүлэлт юм.


**Зураг 2.2.13 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг, сүүлийн 24 жилд**



**Зураг 2.2.14 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэрэг, 1990-2014 он****Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг**

Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2014 онд 1750 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.4 хувийг эзэлж байна. Бүртгэгдсэн нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 46.7 хувь нь бүртгэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй, 34.7 хувь нь ял сонгосон хэрэг байгаа ба энэ төрлийн хэргийн илрүүлэлт 74.3 хувьтай байна.

**Зураг 2.2.15 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 2004-2014 он**

**Зураг 2.2.16 Танхайрах гэмт хэрэг, 1990-2014 он**

Танхайн гэмт хэрэг 2014 онд 1681 бүртгэгдсэн ба 2013 оныхоос 158 хэрэг буюу 8.6 хувиар буурахад Өмнөговь, Сэлэнгэ, Дорнод, Орхон, Говьсүмбэр, Говь-Алтай, Булган аймгуудад энэ төрлийн гэмт хэргийн тоо өмнөх оныхоос 21.4-50.0 хувь, нийслэлд 7.7 хувиар буурсан нь голлон нөлөөлөв.

Танхайн гэмт хэрэг улсын дүнгээр буурсан хэдий ч 2014 онд Хөвсгөл, Дорноговь, Баянхонгор, Завхан, Өвөрхангай аймгуудад өмнөх оныхоос 41.7-111.1 хувиар өссөн байна. Энэ төрлийн гэмт хэргийн гаралт Дархан-Уул(45), Хэнтий(33), Сүхбаатар(30), Төв(30) аймгуудад хамгийн их гардаг байна.


Улсын хэмжээний нийт танхайн гэмт хэргийн 1336 буюу 79.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 112 буюу 7.7 хувиар буурсан байна. Улаанбаатарт гарсан танхайн гэмт хэргийн 410 буюу 30.7 хувь нь Баянзүрх дүүрэгт, 250 буюу 18.7 хувь нь Баянгол дүүрэгт байна.

Танхайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 74.3 хувь болж өмнөх оныхоос 3.2 пунктээр буурсан байна.

### **Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг**


Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам (ТХХАБАЖ)-ын эсрэг гэмт хэрэг 2014 онд 2143 болж, өмнөх оныхоос 5 хэрэг буюу 0.2 хувиар буурсан байна. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 84.8 хувь болж өмнөх оныхоос 6.3 пунктээр өссөн байна.

**Зураг 2.2.17 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 2004-2014 он**




2014 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 7.8 хувийг ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.6 пунктээр буурсан байна. Энэ төрлийн гэмт хэргийн 49.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 6.9 пунктээр буурсан байна. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 73.3 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (ТХХАБАЖ), 24.9 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэрэг эзэлж байна.

**Зураг 2.2.18 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн бүтэц, дүнд эзлэх хувиар, 2013-2014 он**



Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн дотор голлох хувийг эзэлж байгаа ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг 2013 оныхоос 7.1 пункт, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэрэг 6.8 пунктээр нэмэгдсэн байна. Зам тээврийн ослын үед үүргээ биелүүлэхгүй байх, зугтах хэрэг 2009 оноос хойш тасралтгүй өссөн хэдий ч 2014 онд 148 буюу 21.7 хувиар буурчээ. Харин тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2013 оныхоос 151 буюу 10.6 хувиар өссөн байна.

**Зураг 2.2.19 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэргийн гаралт, 2006-2014 он**



**Хүснэгт 2.2.20 Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн, 2007-2013 он**

	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Гэмт хэргийн улмаас нас барсан хүн	1597	1551	1358	1191	922	901	949	1078
Зам тээврийн ослын улмаас нас барсан	344	313	317	325	363	369	424	503
Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн	7759	9096	8593	7486	8100	8436	9797	11281
Зам тээврийн ослын улмаас гэмтсэн	945	892	920	933	1094	1078	1282	1460

Гэмт хэргийн улмаас 2014 онд 1078 хүн нас барсны 503 буюу 46.7 хувь нь зам тээврийн ослын улмаас нас барсан нь өмнөх оныхоос 79 буюу 2.0 пунктээр өссөн байна.


Гэмт хэргийн улмаас 2014 онд 11281 хүн гэмтсэний 1460 буюу 12.9 хувь нь зам тээврийн ослын улмаас гэмтжээ. Зам тээврийн ослын улмаас нас барсан 503 хүний 138 буюу 27.4 хувь нь Улаанбаатар хотод гарсан хэргийн хохирогч байна. Зам

тээврийн ослын улмаас Төв(67), Сэлэнгэ(27), Дорноговь(25), Хэнтий(26), Ховд(20) аймгуудад хамгийн олон иргэн амь насаа алджээ.

### **Аж ахуйн эсрэг гэмт хэрэг**


Аж ахуйн эсрэг гэмт хэрэг 2014 онд 426 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 192 буюу 82.1 хувиар нэмэгджээ. Аж ахуйн эсрэг гэмт хэрэг улсын хэмжээгээр өсөхөд Улаанбаатар хотод 227 –оор өссөн нь голлон нөлөөлжээ.

**Зураг 2.2.20 Аж ахуйн эсрэг гэмт хэрэг, 2004-2014 он**



Улаанбаатар хотод аж ахуйн эсрэг гэмт хэрэг өсөхөд Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдэд энэ төрлийн гэмт хэрэг өмнөх оныхоос 1.6-6.8 дахин өссөн нь голлон нөлөөлжээ.

**Зураг 2.2.21 Аж ахуйн эсрэг гэмт хэрэг, дүүргээр, 2011-2014 он**






### Албан тушаалын гэмт хэрэг


Албан тушаалын гэмт хэрэг 2014 онд 135 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 29 хэрэг буюу 27.4 хувиар өссөн байна. 1990 оноос хойшхи 23 жилийн хугацаанд 2001 онд албан тушаалын гэмт хэргийн гаралт хамгийн олон бүртгэгджээ.

**Зураг 2.2.22 Албан тушаалын гэмт хэргийн гаралт, 1990-2014 он**



Хээл хахууль авах 24 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2013 оныхоос 12 хэрэг буюу 2 дахин өсч, харин хээл хахууль өгөх гэмт хэрэг өмнөх оныхоос 6 буюу 60.0 хувиар буурсан байна.

**Зураг 2.2.23 Хээл хахуулын гэмт хэрэг, 2006-2014 он**




**Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг**

2014 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 49 буюу 0.2 хувь нь Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг байна. Энэ нь өмнөх оныхоос 6-аар буурсан байна. Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэгт хүнийг хууль бусаар хорих, доромжлох, гүтгэх, хүнийг барьцаалах, хүн худалдаалах гэмт хэргүүд ордог<sup>1</sup>. Энэ төрлийн хэргийн бүрэлдэхүүнд ордог хүн худалдаалах гэмт хэрэг 2009 онд 12, 2010 онд 1, 2011 онд 6, 2013 онд 10 байсан бол 2014 онд 8 болж буурсан байна.

**Зураг 2.2.24 Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг,**

2004-2014 он



Энэ төрлийн гэмт хэргийн 8 буюу 16.3 хувь нь хүн худалдаалах гэмт хэрэг байгаа нь өмнөх оныхоос 1.9 пунктээр буурсан байна. Хүн худалдаалах 8 хэргийн 4 буюу 50.0 хувь нь Улаанбаатар хотод гарсан байна. 2014 онд энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 77.8 хувь байгаа нь өмнөх оныхоос 11.1 пунктээр өссөн байна. 2014 онд гарсан 49 хэргийн 20 буюу 40.8 хувь нь доромжлох, 19 буюу 38.8 хувь нь гүтгэх, 2 буюу 4.1 хувь нь хүн барьцаалах, 8 буюу 16.3 хувь нь хүн худалдаалах гэмт хэрэг байна.


**Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг, төрлөөр**

Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 2014 онд 397 болж, өмнөх оныхоос 28 хэрэг буюу 6.6 хувиар буурсан байна. Энэ төрлийн хэргийн 75.6

хувийг эзэлж байгаа хүчингийн хэрэг 2014 онд 300 бүртгэгдэж, өмнөх оныхоос 44 хэрэг буюу 12.8 хувиар буурч, хүүхэд хаях, төөрүүлэх гэмт хэрэг 18 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 4 хэрэг буюу 28.6 хувиар нэмэгдсэн байна ( Хүснэгт 2.2.21).


Хүүхэд хаях, төөрүүлэх 18 хэрэг бүртгэгдсэн нь бүгд Улаанбаатар хотод бүртгэгджээ. Дүүргүүдээс Баянгол дүүрэг(9)-т хамгийн олон хүүхэд хаях, төөрүүлэх хэрэг гарсан байна.

**Зураг 2.2.25 Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг, 2004-2014 он**




**Хүснэгт 2.2.21 Хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг, төрлөөр, 2004-2014 он**

	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
<b>Бүгд</b>	<b>408</b>	<b>352</b>	<b>343</b>	<b>384</b>	<b>426</b>	<b>375</b>	<b>410</b>	<b>434</b>	<b>405</b>	<b>425</b>	<b>397</b>
Хүчиндэх	378	320	314	355	354	332	342	367	305	344	300
Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах	-	-	-	-	27	10	10	15	14	13	17

**Зураг 2.2.26 Хүчингийн гэмт хэрэг, 1990-2014 он**

### 2.3 ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН БАЙДАЛ


2014 онд үйлдэгдсэн гэмт хэргийн 6686 буюу 24.5 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг байгаа нь өмнөх оныхоос 280 хэрэг буюу 4.4 хувиар өсөв. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оныхоос өсөхөд Төв(111.6), Хэнтий (41.5), Баянхонгор(27.4), Ховд(25.3), Өмнөговь(16.5), Хөвсгөл(15.0), Сэлэнгэ(14.7), Орхон(12.2), Увс(11.9) хувиар аймгуудад өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 2.3.2).

**Зураг 2.3.1 Гэмт хэрэг үйлдсэн байдал, 2007-2014 он**


Бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 2014 онд 2683 болж, өмнөх оныхоос 236 хэрэг буюу 9.6 хувь, эмэгтэй хүн оролцсон хэрэг 3645 болж, өмнөх оныхоос 485 хэрэг буюу 15.3 хувь, хүүхэд оролцсон хэрэг 1059 болж, 30 хэрэг буюу 2.9 хувиар нэмэгдсэн байна (Зураг 2.3.1).

**Зураг 2.3.2 Сogтуугаар үйлдэгдсэн хэрэг хамгийн олон гарсан аймгууд,**

2014 он




Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэгдэх явдал 2014 онд эрс нэмэгдэж, 1076 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 658 хэрэг буюу 2.6 дахин өссөн байна. Энэ нь нэг талаас иргэдийн Цагдаагийн байгууллагад үйлдэгдсэн хэргийг бүртгүүлэх явдал сайжирсан байх талтай боловч нөгөөтэйгүүр гэр бүлийн хүчирхийлэл нийгэмд газар авч, өсч байгаагийн илэрхийлэл юм.

**Зураг 2.3.3 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг, 2009-2014 он**

Галт зэвсгээр үйлдэгдсэн, урьдчилан үгсэж, тохиролцон бүлгээр үйлдсэн, зохион байгууллалттай бүлгээр үйлдсэн хэргүүд сүүлийн жилүүдэд буурсан байна.


**Зураг 2.3.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал, 2008-2014 он**




## 2.4 ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАРАГ, ЦАГ ХУГАЦАА, ГАЗАР

2014 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 76.8 хувь нь ажлын өдөр, 23.2 хувь нь амралтын өдөр үйлдэгджээ. Нийт гэмт хэргийн 17.0 хувь нь даваа гарагт үйлдэгдсэн бөгөөд үүний 66.6 хувь нь нийслэлд, 33.4 хувь нь аймгуудад байна. Сүүлийн 4 жилийн байдлаар авч үзэхэд жил бүр Даваа гарагт бусад гарагуудаас их хэрэг гардаг байна.

**Зураг 2.4.1 Үйлдэгдсэн гэмт хэрэг гарагаар, дүнд эзлэх хувиар, 2011-2014 он**



**Зураг 2.4.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн гарагаар, дүнд эзлэх хувиар, 2014 он**



2014 онд бүртгэгдсэн гэмт хэргийн зонхилох хэсэг нь 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн байгаа бөгөөд энэ дүр зураг нийслэл, аймагт ижил байна. Улсын хэмжээгээр бүртгэгдсэн гэмт хэргийн 21.1 хувь нь 06-14 цагт, 26.8 хувь нь 14-19 цагт, 16.2 хувь нь 19-22 цагт, 35.9 хувь нь 22-06 цагийн хооронд үйлдэгджээ.

**Зураг 2.4.3 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн цагаар, 2014 он**



Улаанбаатар хотод 2014 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 33.5 хувь нь шөнийн 22 цагаас өглөөний 06 цагийн хооронд, 27.5 хувь нь 14-19 цагийн хооронд, 23.5 хувь нь 06-14 цагийн хооронд, 15.5 хувь нь 19-22 цагийн хооронд үйлдэгдсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 29.2 хувь нь гэр, орон сууцанд, 20.6 хувь нь гудамж, талбайд үйлдэгджээ.



**Зураг 2.4.4 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, 2014 он**




Гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэргийн 38.2 хувь нь гэрт, 22.7 хувь нь орон сууцны байранд, 26.1 хувь нь хувийн байшин, зуслангийн байшин, амины орон сууцанд, 7.9 хувь нь гарааж, амбаар, агуулах, орц, подвальд, 5.1 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна. Гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн 38.9 хувь нь гэр хорооллын гудамжинд, 29.2 хувь нь орон сууцны хорооллын гудамжинд үйлдэгджээ.

Олон нийтийн газарт үйлдэгдсэн хэргийн 19.4 хувь нь дэлгүүрт, 23.2 хувь нь бааранд, 10.6 хувь нь худалдаа үйлчилгээний захад, 10.4 хувь нь зочид буудалд үйлдэгдсэн байна.

Авто зам дээр гарсан гэмт хэргийн 52.8 хувь нь хотын замд, 41.4 хувь нь орон нутгийн замд гарсан ба замын хучилтаар авч үзвэл, 71.2 хувь нь асфальтан зам дээр, замын гадаргуугийн хувьд 62.3 хувь нь хуурай гадаргууд, замын онцлогоор харвал 57.0 хувь нь тэгш, 48.9 хувь нь шулуун замд үйлдэгджээ.

Авто зам дээр үйлдэгдсэн 2075 хэргийн зонхилох хэсэг 1448 буюу 69.8 хувь нь үзэгдэх орчин чөлөөтэй зам дээр үйлдэгджээ. Үзэгдэх орчин чөлөөтэй зам дээр үйлдэгдсэн хэрэг өмнөх оныхоос 8.6 хувь, зорчих хэсэг гэрэлтүүлэгтэй зам дээр гарсан хэрэг 41.5 хувь, үзэгдэх орчин хангалтгүй зам дээр гарсан хэрэг 38.7 хувиар өсч, харин зорчих хэсэг гэрэлтүүлэггүй зам дээр гарсан хэрэг өмнөх оныхоос 12.4 хувь, хязгаарлагдмал зам дээр гарсан хэрэг 3.9 хувиар буурсан байна.

**Зураг 2.4.5 Авто зам дээр гарсан хэрэг, үзэгдэх орчноор, 2013-2014 он**


Бусад газарт үйлдэгдсэн гэмт хэргийн 46.0 хувь нь хөдөө хээр, бэлчээрт үйлдэгдсэн байна.

## 2.5 ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧИД

Хуулиар тогтоосон үндэслэл журмын дагуу хэрэг үүсгэж сэжигтнээр татагдсан этгээдийг сэжигтэн, харин хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж яллагдагчаар татагдсан этгээдийг яллагдагч гэнэ.

Хэрэгт холбогдсон нийт сэжигтэн, холбогчдын тоо 2014 онд 23.7 мянган хүн болж, өмнөх оныхоос 1451 хүн буюу 6.5 хувиар өссөн байна. (Зураг 2.5.1).


**Зураг 2.5.1 Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогч ба Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, 2005-2014 он**



2014 онд сэжигтэн, холбогдогчоор татагдсан 23.7 мянган хүний 3618 буюу 15.2 хувь нь эмэгтэйчүүд, 1250 буюу 5.3 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна.

Сэжигтэн нь тодорхойгүй байсан 12585 хэргийн 7370 буюу 58.6 хувийнх нь холбогдогч нь тогтоогдож, яллагдагчаар татагдсанаар гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд өмнөх оныхоос 0.1 пунктээр өсч, нийслэлийн хэмжээнд 1.2 пунктээр буурсан байна. Гэмт хэрэгт холбогдогчдын 4.0 хувь нь өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүс байгаа бөгөөд тэдгээрийн эзлэх хувь өмнөх оныхоос 0.4 пунктээр буурчээ.

**Зураг 2.5.2 Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогчид, насны бүлгээр, 2013-2014 он**



Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 49.1 хувь нь ажилгүй иргэд, 6.7 хувь нь оюутан, сурагчид, 33.9 хувь нь ажил, хөдөлмөр эрхэлж буй хүмүүс байна.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогчдод ажилгүй иргэдийн эзлэх хувь 49.1 болж өмнөх оныхоос 1.6 пункт, хувийн байгууллагад ажиллагчдынх 8.8 хувь болж 0.7

пункт, төрийн бус байгууллагынх 2.3 хувь болж 0.1 пункт сурагчдынх 2.5 хувь болж 0.1 пунктээр буурч, малчдынх 9.0 хувь, төрийн албан хаагчийнх 4.4 хувь болж өмнөх оны түвшинд, харин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийнх 18.5 хувь болж, 2.8 пунктээр нэмэгдсэн байна.

**Зураг 2.5.3 Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогч, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, дүнд эзлэх хувиар, 2013-2014 он**



Хэрэгт холбогдсон нийт сэжигтэн холбогдогчдыг боловсролын түвшингээр нь авч үзвэл 43.2 хувийг бүрэн дунд боловсролтой, 21.5 хувийг суурь боловсролтой,

18.5 хувийг дээд боловсролтой, 9.3 хувийг бага боловсролтой хүмүүс эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос бүрэн дунд боловсролтой сэжигтэн, яллагдагчдын эзлэх хувь 1.2 пункт, дээд боловсролтойнх 1.4 пункт, тусгай мэргэжлийнх 0.4 пунктээр өсч, бага боловсролтойнх 0.6 пункт, суурь боловсролтойнх 2.3 пунктээр буурсан байна.

#### **Зураг 2.5.4 Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогч, боловсролын**

*түвшингээр, дүнд эзлэх хувиар, 2013-2014 он*



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын 25.3 хувь нь согтуугаар, 18.5 хувь нь бүлэглэж, 0.4 хувь нь урьдчилан үгсэн тохиролцож гэмт хэрэг үйлдсэн бол 55.8 хувь нь тодорхой шалтгаангүйгээр гэмт хэрэг үйлджээ. Нийт сэжигтэн холбогдогчдын 4.6 хувь нь өмнөх ял шийтгэлийн хугацаа нь дуусаагүй хүмүүс байна.


### 3. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ

#### 3.1 Гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, байгууллага

Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдлээс баттай хамгаалагдсан байх явдал юм.

Нэг ч хүн хохирохгүй байх нөхцлийг бүрдүүлсэн улс орны туршлага хаа ч байхгүй бөгөөд байх ч боломжгүй. Гэхдээ л иргэдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг тасралтгүй үр ашигтай явуулах, нэгэнт хохирсон тохиолдолд түүний хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх эрх зүйн тогтолцоо, үйл ажиллагааны зохистой нөхцлийг цогцоор нь бүрдүүлэх явдал нь аль ч улс орны хувьд нэн чухал байдаг байна.


Зураг 3.1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба хохирогч иргэд, 2007-2014 он



Сүүлийн 8 жилд жил тутам дунджаар 22.0 мянган хэрэг Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж, 21.4 мянган хүн гэмт хэргийн хохирогч болжээ. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 7659 нь эмэгтэй, 1224 нь хүүхдүүд байна.

Гэмт хэргийн улмаас 2014 онд нийт 27.5 мянган иргэн, 118 байгууллага хохирсон нь 2013 оныхоос хохирогч иргэдийн тоо 2460 хүнээр нэмэгдэж, харин хохирогч байгууллагын тоо 39-өөр буурчээ. Гэмт хэргийн улмаас хохирсон эмэгтэйчүүдийн тоо 10.9 мянга болж, өмнөх оныхоос 1064 хүнээр өссөн байна. Хохирсон иргэдийн 60.3 хувь нь эрэгтэйчүүд болсон нь өмнөх оныхоос 0.4 пунктээр буурсан байна.

Зураг 3.1.2 Хохирсон иргэд, 2007-2014 он




Хүснэгт 3.1.1 Хохирогч иргэд, байгууллага, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2007-2013 он

	Нийт хүн амын тоо	Хохирогч иргэдийн тоо			Хохирогч байгууллагын тоо			Учирсан хохирол тэрбум.төг			Нөхөн төлүүлэлт тэрбум.төг	10000 хүн тутмаас хохирсон хүн
		Нийт	Эмэгтэй	18 хүртэлх насны хүүхэд	Нийт	Төрийн	Хувийн	Нийт	Төрийн	Хувийн		
2007 он	2 620 446	19 931	6 115	1 151	975	456	446	29.5	10.9	15.8	4.0	76
2008 он	2 665 955	20 256	6 175	1 080	1 044	490	396	54.8	10.9	22.7	7.0	76
2009 он	2 716 275	19 545	6 312	1 045	824	468	307	49.2	13.6	25.8	18.0	72
2010 он	2 760 968	19 381	7 097	1 066	358	234	74	33.4	8.8	24.4	14.3	70
2011 он	2 811 666	18 592	6 856	1 178	184	128	42	35.9	10.0	25.4	18.5	66
2012 он	2 867 744	21 294	7 977	1 270	167	88	55	53.3	9.6	42.8	25.1	74
2013 он	2 930 277	25 015	9 838	1 426	157	99	48	159.0	79.0	72.9	111.3	85
2014 он	2 937 927	27475	10 902	1 576	118	67	40	148.3	51.5	94.3	43.7	93


2013 оны байдлаар Монгол Улсын 10000 хүн тутмаас 85 хүн гэмт хэргийн хохирогч болсон бол 2014 онд 93 болж, өмнөх оныхоос 8 буюу 9.4 хувиар нэмэгдсэн байна. Харин 2013 онд 10000 хүн тутмын 35 нь эмэгтэй хохирогч, 5 нь 18 хүртэлх насны хохирогч хүүхэд байсан бол 2014 онд 10 000 хүн тутмаас 36 эмэгтэй, 5 нь 18 хүртэлх насны хүүхэд болж, 10 000 хүн тутамд ногдох эмэгтэй хохирогч 1-ээр өсч, 18 хүртэлх насны хүүхдийн тоо өмнөх оны түвшинд байна.



**Зураг 3.1.3 Хохирсон иргэд, хүйсээр, 2007-2014 он**



**Зураг 3.1.4 Гэмт хэргийн улмаас хохирсон нийт иргэд, насны бүлгээр, 2013-2014 он**



25-29 насны хохирогч иргэдийн тоо өмнөх оныхоос 1.3 пункт, 30-34 насных 0.1 пункт, 40-44 насных 0.3 пункт, 50-54 насных 0.4 пункт, 55-59 насных 0.6 пункт, 60-64 насных 0.2 пунктээр өсч, бусад насны бүлгүүд буурсан байна. 18 хүртэлх насны хохирогчдын 13.0 хувь нь 7 хүртэлх насны, 24.7 хувь нь 8-13 насны, 62.3 хувь нь 14-17 насны хүүхдүүд байна.


Хохирогчдын 30.1 хувийг нь ажилгүй иргэд эзэлж байгаа нь 2013 оныхоос 296 хүн буюу 1.7 пунктээр өсчээ. Хохирогч иргэдийн 9.0 хувь нь оюутан, сурагчид, 8.8 хувь нь төрийн албан хаагчид байна. Нийт хохирсон төрийн албан хаагчдын 173 буюу 7.2 хувь нь цагдаагийн албан хаагчид байна.

### **Хүснэгт 3.1.2 Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд, гэмт хэргийн төрлөөр, 2007-2014 он**

Гэмт хэргийн зүйл анги	Хохирогч хүүхэд							
	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	1	-	-	-	-	-	-
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	290	363	350	343	375	391	398	453
Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	-	2	1	-	1	2	6	2
Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	202	158	170	184	202	196	202	182
Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	2	3	1	2	5	11	5	4
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	330	246	204	187	210	269	373	471
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	1	1	-	4	-	-	7	2
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	86	75	75	95	125	115	102	101
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	41	67	85	67	50	41	85	62
Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	-	-	-	1	-	-	1	-
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	195	162	158	181	208	244	246	297
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	1	-
Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	3	1	1	2	2	-	-	2
Албан тушаалын гэмт хэрэг	-	1	-	-	-	-	-	-
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	1	-	-
<b>Улсын дүн</b>	<b>1 151</b>	<b>1 080</b>	<b>1 045</b>	<b>1 066</b>	<b>1 178</b>	<b>1 270</b>	<b>1 426</b>	<b>1 576</b>

Сүүлийн 8 жилийн байдлаар жил тутам дунджаар 1200 гаруй хүүхэд гэмт хэргийн улмаас хохирдог байна. Хүүхдүүд ихэвчлэн Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг, Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг, Өмчлөх эрхийн эсрэг, ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас хохирдог байна.


Гэмт хэргийн улмаас хохирсон гадаад улсын иргэдийн тоо 2014 оны эцэст 176 болж, өмнөх оныхоос 50 хүн буюу 39.7 хувиар нэмэгдсэн байна. Гэмт халдлагаэртсөн гадаадын иргэдийн 46.0 хувь нь БНХАУ-ын иргэд, 21.0 хувь БНСУ-ын иргэд байна.

**Зураг 3.1.5 Гэмт халдлагад өртсөн гадаадын иргэд, улсаар, 2011-2014 он**

Хохирогч өөрийн буруугаас болж хохирсон тохиолдол 293 гарсан нь 2013 оныхоос 72 буюу 19.7 хувиар буурчээ. Архидан согтуурсны улмаас 372 хүн хохирсон нь өмнөх оныхоос 1 хүн буюу 0.3 хувиар өсчээ.


### 3.2 “ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БОЛ ОРЧИН ЦАГИЙН БООЛЧЛОЛ”

Гэр бүлийн хүчирхийллийг орчин цагийн боолчлол хэмээн олон улсад үздэг байна. “Боолчлол” гэдэг ойлголт зөвхөн нийгмийн түвшинд яригдахаа больж, гэр бүлийн хүрээлэлд буй болжээ.

**Зураг 3.2.1 Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэд, 2008-2014 он**


2014 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 1106 хүн хохирсон нь 2013 оныхоос 787 буюу 3.5 дахин нэмэгдэв. Эдгээр хүмүүсийн 83.6 хувь нь бие махбод, 24.2 хувь нь эдийн засгийн хүчирхийлэлд өртжээ.

**Зураг 3.2.1 Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэд, бүс, нийслэлээр, дүнд эзлэх хувиар, 2008-2014 он**




Хохирогчдын 51.1 хувь нь 1 жил хүртэл, 16.2 хувь нь 1-3 жил, 1.8 хувь нь 8-аас дээш жил хүчирхийлэлд автаж байсан байна. Гэр бүлийн хүчирхийлэлд автсан хүмүүсийн 53.2 хувь нь жилд 1-2 удаа, 3.3 хувь нь байнга хүчирхийлэлд автагджээ.

Гэр бүлийн хүчирхийллээс хохирсон хүмүүсийн 56.8 хувийг эхнэр нь, 11.4 хувийг хамтран амьдрагч нь, 3.4 хувийг төрсөн хүүхэд нь, 1.4 хувийг дагавар хүүхэд нь эзэлж байна.

**Зураг 3.2.2 Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэд, дүүргээр, 2009-2014 он**

Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэдийн дийлэнх нь Улаанбаатар хотод байна. 2014 онд Хөвсгөл(48), Орхон(43), Увс(37), Архангай(35), Сэлэнгэ(34), Баян-Өлгий(33) аймагт хамгийн олон иргэн гэр бүлийн хүчирхийлэлд автсан байна. Дүүргүүдээс Баянзүрх, Баянгол дүүргүүдэд гэр бүлийн хүчирхийлэл хамгийн их гарсан байна.

**Зураг 3.2.3 Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэд, хүчирхийллийн хэлбэрээр, 2008-2014 он**


**Хүснэгт 3.2.1 Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэдийн хамаарал, хувиар, 2013-2014 он**

д/д	Хохирогчийн хамаарал	Нэгж	2013	2014	Өөрчлөлт	
					пункт	↑↓
1	Эхнэр	хувь	67.7	58.0	(9.7)	↓
2	Нөхөр	хувь	6.3	14.9	8.6	↑
3	Хамтран амьдрагч	хувь	12.5	12.4	(0.2)	↓
4	Хүргэн, бэр	хувь	0.9	2.2	1.2	↑
5	Төрсөн эцэг, эх	хувь	1.6	1.2	(0.4)	↓
6	Хадам эцэг, эх, ах, эгч, дүү	хувь	1.9	2.6	0.7	↑
7	Төрсөн эгч, ах	хувь	1.3	1.1	(0.2)	↓
8	Төрсөн дүү	хувь	0.9	1.1	0.1	↑
9	Төрсөн хүүхэд	хувь	3.4	3.4	(0.0)	↓
10	Үрчилж авсан хүүхэд	хувь	-	0.1	-	↑
11	Дагавар хүүхэд	хувь	2.5	1.6	(0.9)	↓
12	Төрөл төрөгсөд	хувь	0.9	1.1	0.1	↑
13	Хойд эцэг	хувь	-	0.3	-	↑
14	<b>Улсын дүн</b>		<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>-</b>	<b>-</b>

### 3.3 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН БАЙГУУЛЛАГА


Гэмт хэргийн улмаас нийт 118 байгууллага хохирсон нь 2013 оныхоос 39 байгууллага буюу 24.8 хувиар буурчээ. Хохирогч байгууллагын тоо буурахад 2014 онд Дорноговь аймаг, Улаанбаатар хотын хохирогч байгууллагын тоо буурсан нь голлон нөлөөлжээ.

**Зураг 3.3.1 Хохирсон байгууллага, 2007-2014 он**




Байгууллагын төрлөөр нь авч үзвэл 2014 онд хохирсон байгууллагын 56.8 хувь нь төрийн , 9.3 хувь нь төрийн бус, 33.9 хувь нь хувийн байгууллага байгаа бөгөөд өмнөх оныхоос төрийн байгууллага 6.3 пунктээр буурч, төрийн бус байгууллага 3.0 пункт, хувийн байгууллага 3.3 пунктээр өссөн байна.

**Зураг 3.3.2 Хохирсон байгууллага, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2007-2014 он**



### 3.4 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ГЭМТСЭН, НАС БАРСАН ИРГЭД

**Зураг 3.4.1 Гэмт хэргийн улмаас нас барсан, гэмтсэн иргэд, 2007-2014 он**




Гэмт хэргийн улмаас 2014 онд 27475 иргэн хохирсны 1078 буюу 3.9 хувь нь нас барж, 11281 буюу 41.1 хувь нь гэмтсэн байна. Хохирогч иргэдийн тоо өмнөх оныхоос 9.8 хувиар, нас барсан иргэдийн тоо 13.6 хувь, гэмтсэн иргэдийн тоо 15.1 хувиар нэмэгджээ.

**Хүснэгт 3.4.1 Нас барсан иргэд, насны бүлгээр, 2010-2014 он**

д/д	Насны бүлэг	Нас барсан иргэд					Дүнд эзлэх хувь				
		2010	2011	2012	2013	2014	2010	2011	2012	2013	2014
1	7 хүртэлх	48	43	42	41	62	4.0	4.7	4.7	4.3	5.8
2	8-13	25	15	12	10	15	2.1	1.6	1.3	1.1	1.4
3	14-17	13	19	26	23	24	1.1	2.1	2.9	2.4	2.2
4	18-24	126	114	120	88	120	10.6	12.4	13.3	9.3	11.1
5	25-29	121	87	93	110	129	10.2	9.4	10.3	11.6	12.0
6	30-34	173	116	116	122	112	14.5	12.6	12.9	12.9	10.4
7	35-39	161	119	109	128	140	13.5	12.9	12.1	13.5	13.0
8	40-44	151	123	95	93	116	12.7	13.3	10.5	9.8	10.8
9	45-49	155	103	103	117	117	13.0	11.2	11.4	12.3	10.9
10	50-54	100	90	89	90	98	8.4	9.8	9.9	9.5	9.1
11	55-59	41	45	38	45	63	3.4	4.9	4.2	4.7	5.8
12	60-64	29	19	26	38	34	2.4	2.1	2.9	4.0	3.2
13	65-69	14	16	14	19	25	1.2	1.7	1.6	2.0	2.3
14	70 ба түүнээс дээш	34	13	18	25	23	2.9	1.4	2.0	2.6	2.1
<b>Улсын дүн</b>		<b>1 191</b>	<b>922</b>	<b>901</b>	<b>949</b>	<b>1 078</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Нас барсан иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 2014 онд 18-54 насныхан зонхилон амь насаа алджээ. Нас барсан иргэдийн тоо өмнөх оныхоос өсөхөд 18-24 насных 1.8 пункт, 7 хүртэлх насных 1.5 пункт, 55-59 насных 1.1 пунктээр өссөн нь голлон нөлөөлжээ. Нас барсан иргэдийн 270 буюу 25.0 хувь нь эмэгтэй, 101 буюу 9.4 хувь нь хүүхдүүд байна.

Нас барсан хүмүүсийн 91.4 хувь нь 24 цагийн дотор, 7.7 хувь нь 30 хоногийн дотор, 0.9 хувь нь 30-аас дээш хоногт эмнэлгийн тусламж авсан байна.

**Зураг 3.4.2 Гэмт хэргийн улмаас нас барсан иргэд, хэргийн төрлөөр, 2013-2014 он**



Гэмт хэргийн улмаас 2014 онд 1078 хүн нас барсны 203 буюу 18.8 хувь нь хүнийг санаатай алсан, 503 буюу 46.7 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмыг зөрчсөн, 245 буюу 22.7 хувь нь бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн улмаас амь насаа алджээ. Гэмт хэргийн улмаас 101 хүүхэд нас барж, 817 хүүхэд гэмтсэн байна.

Гэмт хэргийн улмаас 2014 онд 11281 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос 1484 хүн буюу 15.1 хувиар нэмэгдэв. Гэмтсэн хүмүүсийн 62.1 хувь нь эрэгтэйчүүд, 37.9 хувь нь эмэгтэйчүүд, 7.2 хувь нь хүүхдүүд байна.

Нийт гэмтсэн хүмүүсийн 7561 буюу 67.0 хувь нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 110 буюу 1.0 хувь нь хүчингийн хэрэг, 1459 буюу 12.5 хувь нь танхайрах гэмт хэрэг, 1460 хүн буюу 12.9 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн байна.


### Хүснэгт 3.4.2 Гэмтсэн иргэд, насны бүлгээр, 2010-2014 он

д/д	Насны бүлэг	Гэмтсэн хүний тоо					Дүнд эзлэх хувь				
		2010	2011	2012	2013	2014	2010	2011	2012	2013	2014
1	7 хүртэлх	69	86	85	114	127	0.9	1.1	1.0	1.2	1.1
2	8-13	141	194	188	182	196	1.9	2.4	2.2	1.9	1.7
3	14-17	358	421	435	425	494	4.8	5.2	5.2	4.3	4.4
4	18-24	1 611	1 945	1 902	1 937	2 119	21.5	24.0	22.5	19.8	18.8
5	25-29	1 327	1 478	1 558	1 875	2 226	17.7	18.2	18.5	19.1	19.7
6	30-34	1 126	1 073	1 269	1 565	1 734	15.0	13.2	15.0	16.0	15.4
7	35-39	878	979	981	1 228	1 426	11.7	12.1	11.6	12.5	12.6
8	40-44	723	697	747	830	1 072	9.7	8.6	8.9	8.5	9.5
9	45-49	530	532	534	657	762	7.1	6.6	6.3	6.7	6.8
10	50-54	333	317	380	498	554	4.4	3.9	4.5	5.1	4.9
11	55-59	177	170	180	227	267	2.4	2.1	2.1	2.3	2.4
12	60-64	93	92	74	106	138	1.2	1.1	0.9	1.1	1.2
13	65-69	43	56	40	70	72	0.6	0.7	0.5	0.7	0.6
14	70 ба түүнээс дээш	77	60	63	83	94	1.0	0.7	0.7	0.8	0.8
Улсын дүн		7 486	8 100	8 436	9 797	11 281	100.0	100.0	100.0	100.0	100.0

Гэмтсэн иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 2014 онд 18-44 насныхан зонхилон гэмтэж бэртсэн байна. Гэмтсэн иргэдийн тоо өмнөх оныхоос өсөхөд 40-44 насных 1.0 пункт, 25-29 насных 0.6 пунктээр өссөн нь голлон нөлөөлжээ.

2014 онд гэмт хэргийн улмаас гэмтсэн хүмүүсийн 77.4 хувь нь хөнгөн, 14.6 хувь нь хүндэвтэр, 8.1 хувь нь хүнд гэмтсэн байна.

Зураг 3.4.3 Гэмтсэн иргэд, гэмтлийн зэргээр, дүнд эзлэх хувиар, 2013-2014 он



Хүснэгт 3.4.3 Гэмтсэн иргэд, хэргийн төрлөөр, 2007-2014 он


	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4	2	5	-	-	-	-	-
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	4 437	5 182	5 479	4 600	4 868	5 371	6 288	7 561
Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	-	3	6	1	1	1	-	-
Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	202	233	192	154	150	121	112	122
Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	36	45	35	31	46	58	81	103
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	374	919	365	233	265	258	276	295
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	1	2	1	3	2	-	-	-
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1 497	1 496	1 284	1 242	1 416	1 302	1 465	1 434
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	190	236	243	238	195	177	220	215
Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	1	2	1	1	-	1	2	6
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	945	892	920	933	1 094	1 078	1 282	1 460
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	46	60	40	42	55	57	64	71
Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	6	10	6	2	4	5	1	8
Албан тушаалын гэмт хэрэг	7	2	7	-	-	-	-	-
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	13	12	9	6	4	7	6	6
<b>Улсын дүн</b>	<b>7 759</b>	<b>9 096</b>	<b>8 593</b>	<b>7 486</b>	<b>8 100</b>	<b>8 436</b>	<b>9 797</b>	<b>11 281</b>

Сүүлийн 8 жилд гэмт хэргийн улмаас гэмтсэн иргэдийн 43786 буюу 62.1 хувь нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, 11136 буюу 15.8 хувь нь Нийгмийн аюулгүй байдлын эсрэг, 8604 буюу 12.2 хувь нь ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтэж бэртсэн байна. 2014 онд гэмтсэн иргэдийн тоо өсөхөд Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 1273 буюу 20.2 хувь, ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг 178 буюу 13.9 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.


### 3.5 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ

Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирол 2014 онд 148.3 тэрбум төг болж, өмнөх оныхоос 10.7 тэрбум төг буюу 6.7 хувиар буурч, харин нөхөн төлүүлэлт 43.7 тэрбум төг болж, 67.6 тэрбум төг буюу 60.8 хувиар буурсан байна (Зураг 3.2.1).

**Зураг 3.5.1 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, тэрбум төг, оноор**




**Зураг 3.5.2 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэмт хэргийн ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2007-2014 он**




2014 онд хүндэвтэр гэмт хэрэг 31.9 пунктээр өсч, харин хүнд гэмт хэрэг 18.4 пункт, онц хүнд 10.1 пункт, хөнгөн 3.4 пунктээр буурчээ.

**Зураг 3.5.3 Учирсан хохирол, бүс, нийслэлээр, 2007-2014 он**



Жил тутам гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 63.8-84.1 хувийг Улаанбаатар хот эзэлдэг байна. 2014 онд улсын хэмжээгээр нийт учирсан хохирлын 117.1 тэрбум төг буюу 79.0 хувийг нийслэлд учирсан хохирол эзэлж байгаа боловч өмнөх оныхоос 16.6 тэрбум буюу 12.4 хувиар буурсан байна. Нийслэлийн дүүргүүдээс Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хохирол хамгийн их учирчээ.


**Зураг 3.5.4 Хохирлын нөхөн төлүүлэлт, хувиар, 2011-2014 он**



### 3.6. ЭРҮҮЛЖҮҮЛЭГДСЭН, БАРИВЧЛАГДСАН ИРГЭД

2014 онд 119.0 мянган хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оныхоос 4.5 мянга буюу 3.8 хувиар буурсан байна. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж эрүүлжүүлэгдсэн 119.0 мянган хүний 64.9 мянга буюу 54.6 хувь нь нийслэлд, 50.7 мянга буюу 42.6 хувь нь аймгуудад, 3.3 буюу 2.8 хувь нь төмөр замд эрүүлжүүлэгдэж, үйлчилгээний төлбөрт нийт 413.2 сая төгрөгийг төлсөн байна.

**Зураг 3.6.1 Эрүүлжүүлэгдсэн нийт хүн, мян.хүнээр, оноор**




Эрүүлжүүлэгдсэн хүний тоо өмнөх оныхоос 4.4 мянгаар буурахад Өвөрхангай 746 буюу 44.7 хувь, Дорноговь 1141 буюу 32.4 хувь, Сүхбаатар 846 буюу 29.8 хувь, Завхан 479 буюу 20.8 хувь, Говь-Алтай 236 буюу 21.1 хувь, Дундговь 215 буюу 18.6 хувь, Архангай 90 буюу 15.6 хувиар эрүүлжүүлэгдсэн хүний тоо буурсан нь голлон нөлөөлжээ.

Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн 6124 буюу 5.1 хувь нь эмэгтэйчүүд, 673 буюу 0.6 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 126 буюу 0.1 хувь нь гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүс байна.


Нийт эрүүлжүүлэгдсэн хүмүүсийг нийгмийн байдлаар нь авч үзвэл 97026 буюу 81.5 хувь нь ажилгүй иргэд, 9165 буюу 7.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1166 буюу 1.0 хувь нь ажилчин, малчин, 3539 буюу 3.0 хувь нь хувийн хэвшилд ажиллагчид, 1027 буюу 0.9 хувь нь оюутан, сурагчид, 1547 буюу 1.3 хувь нь төрийн албан хаагчид байна.

Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн 435 буюу 0.4 хувь нь архины албадан эмчилгээнд хамрагдаж, 530 буюу 0.4 хувь нь сайн дураараа архины эмчилгээнд хамрагджээ.

### Зураг 3.6.2 Эрүүлжүүлэгдсэн хүн, бүс, нийслэлээр, 2010-2014 он



Жил бүр нийт эрүүлжүүлэгдсэн иргэдийн 50-аас дээш хувь нь Улаанбаатар хотод эрүүлжүүлэгддэг байна. Дүүргүүдээс 2014 онд Баянзүрх (14722), Сонгинохайрхан (12831)-д хамгийн олон хүн эрүүлжүүлэгдсэн байна.

**Зураг 3.6.3 Эрүүлжүүлэгдсэн хүн, согтолтын зэргээр, хувиар, 2010-2014 он**


Нийт эрүүлжигдсэн иргэдийн 90 гаруй хувь нь дунд зэргийн согтолтой байдаг байна. 2010 онд эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн 6.9 хувь нь хүнд зэргийн согтолтой байсан бол жил тутам буурсаар 2014 онд хүнд зэргийн согтол 3.8 хувь болж, 2010 оныхоос 3.1 пункт, 2011 оныхоос 2.6 пункт, 2012 оныхоос 1.7 пункт, 2013 оныхоос 0.1 пунктээр буурсан байна.

**Хүснэгт 3.6.1 Эрүүлжүүлэгдсэн хүн, бүс, нийслэлээр, 2010-2014 он**

	2010	2011	2012	2013	2014
<b>Улсын дүн</b>	<b>109799</b>	<b>115349</b>	<b>118030</b>	<b>123454</b>	<b>119015</b>
<b>Баруун бүс</b>	<b>10114</b>	<b>9988</b>	<b>10987</b>	<b>9667</b>	<b>8433</b>
Баян-Өлгий	850	1340	1079	1236	1143
Говь-Алтай	1426	1551	1086	1116	880
Завхан	1917	1308	2852	1713	1234
Увс	1784	1639	2051	2370	2041
Ховд	4137	4150	3919	3232	3135
<b>Хангайн бүс</b>	<b>11259</b>	<b>11989</b>	<b>12191</b>	<b>12539</b>	<b>12132</b>
Архангай	1149	1212	856	576	486
Баянхонгор	982	1212	1530	2144	2591
Булган	769	732	692	804	796
Орхон	4527	4675	5404	5165	5005
Өвөрхангай	1300	1760	1516	1670	924
Хөвсгөл	2532	2398	2193	2180	2330
<b>Төвийн бүс</b>	<b>16620</b>	<b>18890</b>	<b>19522</b>	<b>19772</b>	<b>17686</b>
Говьсүмбэр	1179	946	985	1541	1431
Дархан-Уул	5377	5498	5642	5444	5836
Дорноговь	2333	3141	3426	3524	2383
Дундговь	830	1353	928	1158	943
Өмнөговь	1988	1755	2504	2753	2482
Сэлэнгэ	3874	5118	4716	4015	3456
Төв	1039	1079	1321	1337	1155
<b>Зүүн бүс</b>	<b>13395</b>	<b>13106</b>	<b>13168</b>	<b>13744</b>	<b>12430</b>
Дорнод	7613	7770	7199	7226	7229
Сүхбаатар	2772	2849	3098	2840	1994
Хэнтий	3010	2487	2871	3678	3207
Улаанбаатар	55145	59017	59529	63903	64943
Төмөрзам	3266	2359	2633	3829	3391

2014 онд захиргааны зөрчлийн улмаас 17.1 мянган хүн баривчлагдсан нь 2006 оныхоос 3570 буюу 26.4 хувь, 2013 оныхоос 585 буюу 3.5 хувиар нэмэгдсэн байна.



**Зураг 3.6.4 Баривчлагдсан нийт хүн, 2005-2014 он**


#### 4. ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРЭГ

Шүүхээр шийдвэрлүүлэхээр 2014 онд 7603 хэрэг ирсний 6375 буюу 83.8 хувь нь шийдвэрлэгдэж, 694 буюу 9.1 хувь нь мөрдөн байцаалтанд буцаж, 18 буюу 0.2 хувь нь хэрэг бүртгэлд буцаж, 23 буюу 0.3 хувь нь харьяаллын дагуу шилжсэнээр 493 буюу 6.5 хувь нь шийдвэрлэгдээгүй үлдсэн байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг өмнөх оныхоос 1.3 пункт, тайлант хугацааны үлдэгдэл хэрэг 1.3 пунктээр буурч, харин мөрдөн байцаалтанд буцсан хэрэг 2.3 пунктээр өссөн байна.

**Хүснэгт 4.1.1 Анхан шатны шүүхийн хэрэг, 2009-2014 он**

	2009	2010	2011	2012	2013	2014
Хэргийн тоо - бүгд	6 304	6 372	6 776	7 065	7 248	7 603
Мөрдөн байцаалтад буцаасан	455	445	440	465	495	694
Хэрэг бүртгэлд буцаасан	27	70	8	7	10	18
Харьяаллын дагуу шилжүүлсэн	3	11	13	12	12	23
Шийдвэрлэсэн	5407	5460	5877	6161	6169	6375
Тайлант хугацааны үлдэгдэл	412	386	438	420	562	493

**Зураг 4.1.1 Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг, 2009-2014 он**


Жил тутам Шүүхээр шийдвэрлүүлэхээр ирсэн хэргийн 83-87 хувь нь шийдвэрлэгддэг байна. Шүүхээр шийдвэрлүүлэхээр ирсэн хэрэг өмнөх оныхоос 355 буюу 4.9 хувиар өсчээ.

**Хүснэгт 4.1.2 Шүүхээр ял шийтгүүлсэн иргэд, 2009-2014 он**


	2009	2010	2011	2012	2013	2014
Ял шийтгүүлсэн хүн	7513	7292	8210	8324	8065	8178
Урьд нь ял шийтгүүлсэн	1637	1645	1460	1544	1698	1919
Гэмт хэрэг давтан үйлдсэн	591	562	471	539	504	455
Бүлэглэн үйлдсэн	1314	1407	1465	1498	1414	1604
Согтуугаар үйлдсэн	1610	1512	1704	1717	1710	1582

Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо 2014 онд 8178 болж, өмнөх оныхоос 113 буюу 1.4 хувиар нэмэгдсэн байна. Тухайн жилд сэжигтэн, яллагдагчаар татагдсан хүмүүсийн 34.5 хувь нь ял шийтгүүлсэн байна.

Ял шийтгүүлэгчдийн 1919 буюу 23.5 хувь нь урьд нь ял шийтгүүлж байсан, 455 буюу 5.5 хувь нь давтан хэрэг үйлдсэн, 1604 буюу 19.6 хувь нь бүлэглэн үйлдсэн, 1582 буюу 19.3 хувь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна. Ял шийтгүүлэгчдийн 718 буюу 8.8 хувь нь эмэгтэйчүүд, 467 буюу 5.7 хувь нь хүүхдүүд байна.


**Зураг 4.1.2 Шүүхээр ял шийтгүүлсэн иргэд, 2005-2014 он**

2014 онд шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийн 48.7 хувийг 18-29 насны залуучууд, 17.5 хувийг 30-34 насныхан, 27.9 хувийг 35-аас дээш насныхан, 5.9 хувийг 18 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байна. Насны бүлгээр нь авч үзвэл ял шийтгүүлсэн 35-аас дээш насныхан өмнөх оныхоос 1.9 пунктээр өсч, харин бусад насны бүлгүүд буурсан байна. Ял шийтгүүлэгчдийн 34 буюу 0.4 хувь нь 55-аас дээш насны эмэгтэйчүүд байна.

**Зураг 4.1.3 Шүүхээр ял шийтгүүлсэн иргэд, насны бүлгээр, 2013-2014 он**

2013 онд шүүхээр ял шийтгүүлсэн иргэдийн 42.9 хувь нь бүрэн дунд, 20.2 хувь нь суурь, 12.2 хувь нь бага боловсролтой байна.

**Зураг 4.1.4 Шүүхээр ял шийтгүүлсэн иргэд, боловсролын түвшинээр, хувиар, 2013-2014 он**



Шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийн 16 буюу 0.2 хувь нь улс төрийн албан тушаалтан, 37 буюу 0.5 хувь нь төрийн захиргааны албан хаагч, 60 буюу 0.7 хувь нь төрийн тусгай албан хаагч, 148 буюу 1.8 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч, 644 буюу 7.9 хувь нь оюутан, сурагчид, 5000 буюу 61.1 хувь нь ажил эрхлээгүй хүмүүс байна.


Ял шийтгүүлсэн иргэдийн 8150 буюу 99.7 хувь нь Монгол улсын иргэд, 28 буюу 0.3 хувь нь гадаадын иргэд байна. 2014 онд ял шийтгүүлсэн 8178 хүний 6277 буюу 76.8 хувь нь хорих ялаар, 1053 буюу 12.9 хувь нь баривчлах ялаар, 285 буюу 3.5 хувь нь торгуулийн ялаар шийтгүүлсэн байна.

**Хүснэгт 4.1.3 Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн хохирол, нөхөн төлүүлэлт, 2007-2014 он**

	Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг	Ял шийтгүүлсэн иргэд	Учирсан хохирол сая.төг	Нөхөн төлүүлэлт сая.төг
2007 он	5 831	8 463	67 035.3	1 154.7
2008 он	5 812	8 494	14 927.6	9 671.9
2009 он	5 407	7 513	19 440.5	1 184.0
2010 он	5 460	7 292	26 312.8	1 955.4
2011 он	5 877	8 210	13 854.6	1 707.6
2012 он	6 161	8 324	21 981.9	2 065.0
2013 он	6 169	8 065	95 896.2	90 822.9
2014 он	6 375	8 178	78 169.4	1 483.0

2014 оны байдлаар шүүхээр 6375 хэрэг шийдвэрлэгдэж, 8178 хүн ял шийтгүүлж, 78.2 тэрбум төгрөгийн хохирол учирч, 1.5 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

**Зураг 4.1.5 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2007-2014 он**




Улсын хэмжээнд 2014 онд нийт учирсан нийт хохирлын 1.9 хувь нь нөхөн төлөгджээ.

## 4.2 ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ХӨДӨЛМӨРИЙН МАРГААН

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулиар 2014 онд 1377 хөдөлмөрийн маргаан шийдвэрлэгдсэний 742 буюу 53.9 хувь нь ажлаас үндэслэлгүй халагдсан, 475 буюу 34.5 хувь нь цалин хөлсний маргаан, 28 буюу 2.0 хувь нь ажлаас буруу шилжүүлсэн хэрэг байна.

**Зураг 4.2.1 Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргаан, бүс, нийслэлээр, 2010-2014 он**



Шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргааны 16.8 хувь нь баруун бүсэд, 13.5 хувь нь хангайн бүсэд, 22.9 хувь нь төвийн бүсэд, 3.8 хувь нь зүүн бүсэд, 43.0 хувь нь Улаанбаатар хотод байна.

Хөдөлмөрийн маргаан 2013 оныхоос 297 буюу 27.5 хувиар нэмэгдэхэд цалин хөлсний маргаан 269 –аар, ажлаас үндэслэлгүй халсан шалтгаан 17-оор өссөн нь голлон нөлөөлжээ.

Монгол Улсын “Дампуурлын тухай” хуулиар 2014 онд 13 аж ахуйн нэгж шүүхийн шийдвэрээр дампуурсан гэдэг нь зарлагдсан бөгөөд эдгээрийн 8 буюу 61.5 хувийнх нь хариуцагчийг татан буулгажээ.

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулиар 2014 онд 12421 хэрэг шийдвэрлэгдсэний 3182 буюу 25.6 хувь нь гэр бүл цуцалсан, 430 буюу 3.5 хувь нь эцэг тогтоосон, 478 буюу 3.8 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэрэг байна. “Гэр бүлийн тухай” хуулийн дагуу шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг өмнөх оныхоос 3150 буюу 20.2 хувиар буурахад гэр бүл цуцлалт 200 буюу 5.9 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн хэдий ч эцэг тогтоох хэрэг 117 буюу 37.4 хувь, хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэрэг 24 буюу 5.3 хувиар өссөн байна.

### 4.3 ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ


Захиргааны зөрчил гэдэг нь бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

**Зураг 4.3.1 Хянан шийдвэрлэсэн захиргааны зөрчил, 2013-2014 он**



Шүүхээр 2014 онд 18.9 мянган захиргааны зөрчил шийдвэрлүүлсний 18.6 мянга буюу 98.7 хувь нь захиргааны арга хэмжээ авагдаж, 248 буюу 1.3 хувь нь арга хэмжээ авахаас татгалзаж буцсан зөрчил байна. Захиргааны арга хэмжээ авагдсан зөрчлийн тоо өмнөх оныхоос 0.2 пунктээр өсч, харин арга хэмжээ авахаас татгалзсан зөрчил 0.2 пунктээр буурчээ.

**Зураг 4.3.2 Торгуулсан ба баривчлуулсан нийт хүн, 2013-2014 он**




2014 онд захиргааны зөрчлийн улмаас 17.9 мянган хүн баривчлагдаж, 754 хүн 13.1 сая төгрөгөөр торгуулсан байна.

## 5. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ

### 5.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар 2014 онд гүйцэтгэвэл зохих 1.3 их наяд төгрөгийн торгуулын 955.9 тэрбум төгрөг буюу 74.2 хувь, 777323 хоногийн эрх хасах ялын 374762 хоног буюу 48.2 хувь, 117346 цагийн албадан ажил хийлгэх ялын 109577 буюу 93.4 хувь, 244.5 тэрбум төгрөгийн эд хөрөнгө хураах ялын 221.9 тэрбум буюу 90.8 хувийг гүйцэтгэжээ.

**Зураг 5.1.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэхийн нөхөн төлүүлэлт, хэргийн төрлөөр, 2011-2014 он**



## 6. УЛС ОРНУУДЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ, БАЙДЛААС


Цагдаагийн байгууллагад 2011 онд хүнийг санаатай алах гэмт хэрэг 266 бүртгэгдсэн бөгөөд 100 000 хүнд ногдох түвшингээр Япон улсаас 9.4 пункт, Тайвань улсаас 6.7 пункт, Казакстан улсаас 0.9 пункт, Киргизстан улсаас 0.6 пунктээр их байна. 100 000 хүнд ногдох хүнийг санаатай алах гэмт хэрэг 2011 онд өмнөх оныхоос Япон улсад 0.1 пункт, Тайвань улсад 0.2 пункт, Киргизстан улсад 11.0 пунктээр буурсан бол харин Казакстан улсад 0.1 пункт, Монгол улсад 0.9 пунктээр өссөн байна.

### Хүснэгт 6.1.1 Хүнийг санаатай алах гэмт хэрэг, сонгосон улсаар, 2003-2011 он

		2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Монгол	хэргийн тоо	343	333	398	336	293	212	219	239	266
	100000 хүнд ноогдох	13.9	13.3	15.8	13.1	11.3	8.1	8.2	8.8	9.7
Япон	хэргийн тоо	697	699	643	619	574	646	506	465	442
	100000 хүнд ноогдох	0.6	0.6	0.5	0.5	0.5	0.5	0.4	0.4	0.3
Тайвань	хэргийн тоо	1057	910	903	921	881	803	832	743	686
	100000 хүнд ноогдох	4.7	4.0	4.0	4.0	3.8	3.5	3.6	3.2	3.0
Казакстан	хэргийн тоо	1991	2091	1804	1729	1656	1642	1604	1387	1420
	100000 хүнд ноогдох	13.5	14.0	12.0	11.4	10.8	10.5	10.2	8.7	8.8
Киргизстан	хэргийн тоо	421	420	419	422	426	429	419	1072	494
	100000 хүнд ноогдох	8.4	8.4	8.3	8.3	8.3	8.3	8.0	20.1	9.1

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл 2011 онд Монгол улсад 2010 оныхоос 19 буюу 13.2 хувь, Казахстанд 48 буюу 48.0 хувиар нэмэгдэж, харин Япон улсад 183 буюу 4.2 хувь, Гонконгд 92 буюу 11.4 хувь, Солонгосд 125 буюу 10.6 хувиар буурсан байна.


### Зураг 6.1.1 Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, сонгосон улсаар, 2007-2011 он





### Зураг 6.1.2 Хүнийг санаатай алах гэмт хэргийн хохирогч, хүйсээр, сонгосон

улсаар, хувиар, 2014 он



Хүнийг санаатай алах гэмт хэргийн хохирогчийг хүйсээр авч үзвэл улс орон болгонд харилцан адилгүй байдаг байна. 2007-2011 оны мэдээллээр Монгол Улсад энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн хүйсийн харьцаа эрэгтэй 72.0-78.0 хувь, эмэгтэй 22.0-28.0 хувьтай байна.

## 7. ДҮГНЭЛТ

Улсын хэмжээнд 2014 онд 27.3 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2013 оныхоос 1956 хэрэг буюу 7.7 хувиар нэмэгдсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өсөхөд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн дүнд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 45.9 хувь болж өмнөх оныхоос 2.1 пункт, Аж ахуйн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 1.6 хувь болж 0.7 пунктээр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Монгол Улсын хэмжээнд жил тутам бүртгэгдсэн гэмт хэргийн тоо нэмэгдэж байгаа нь нэг талаас улс орны эдийн засгийн чадавхитай холбоотой ч нөгөөтэйгүүр хүний хөгжил, хууль эрх зүйн орчин, хувь хүмүүсийн ёс суртахуун, дадал заншил гэх мэтчлэн нийгмийн олон талт үзэгдлүүдтэй холбоотой.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2014 онд 12551 бүртгэгдэж, өмнөх оныхоос 1433 хэрэг буюу 12.9 хувиар өсөхөд энэ төрлийн гэмт хэргийн 67.1 хувийг эзэлж буй хулгайн хэрэг 540-өөр, халаасны хулгайн хэрэг 160-аар, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж, авах хэрэг 612-оор, авто тээврийн хэрэгслийн хулгай 114-өөр өссөн нь голлон нөлөөлжээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнд ордог дийлэнх төрлийн гэмт хэрэг сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай хэдий ч завших, үрэгдүүлэх хэрэг 8.9 хувиар буурсан байна.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 93.5 хувийг бусдын биед гэмтэл учруулах гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 0.8 пунктээр нэмэгджээ. Бусдыг санаатай болон амиа хорлоход хүргэх гэмт хэргийн энэ төрлийн хэргийн дүнд эзлэх хувь буурчээ.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 58.7 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд Дархан-Уул (321), Төв (279), Сэлэнгэ (265), Хөвсгөл (227), Орхон (236), Өвөрхангай (186) аймагт энэ төрлийн гэмт хэргийн гаралт бусад аймгийнхаас их байна.

Хүнийг санаатай алах гэмт хэрэг Ховд, Булган, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймгуудад буурсан хэдий ч Баянхонгор, Орхон, Хөвсгөл, Дархан-Уул, Дорноговь, Төв аймгуудад өмнөх оныхоос нэмэгдсэн байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам (ТХХАБАЖ)-ын эсрэг гэмт хэрэг 2014 онд 2143 болж, өмнөх оныхоос 5 хэрэг буюу 0.2 хувиар буурсан байна. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 84.8 хувь болж өмнөх оныхоос 6.3 пунктээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 2014 онд 1078 хүн нас барсны 503 буюу 46.7 хувь нь зам тээврийн ослын улмаас нас барсан ба өмнөх оныхоос 79 буюу 2.0 пунктээр өссөн байна. Зам тээврийн ослын улмаас нас барсан 503 хүний 138 буюу 27.4 хувь нь Улаанбаатар хотод гарсан хэргийн хохирогч байна. Зам тээврийн ослын улмаас

Төв(67), Сэлэнгэ(27), Дорноговь(25), Хэнтий(26), Ховд(20) аймгуудад хамгийн олон иргэн амь насаа алджээ.

Гэмт хэргийн улмаас 2014 онд 11281 хүн гэмтсэний 1460 буюу 12.9 хувь нь зам тээврийн ослын улмаас гэмтжээ.

Аж ахуйн эсрэг гэмт хэрэг 2014 онд 426 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 192 буюу 82.1 хувиар нэмэгджээ. Аж ахуйн эсрэг гэмт хэрэг улсын хэмжээгээр өсөхөд Улаанбаатар хотод 227 –оор өссөн нь голлон нөлөөлсөн байна. Улаанбаатар хотод аж ахуйн эсрэг гэмт хэрэг өсөхөд Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдэд энэ төрлийн гэмт хэрэг өмнөх оныхоос 1.6-6.8 дахин өссөн нь голлон нөлөөлжээ.

Албан тушаалын гэмт хэрэг 2014 онд 135 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 29 хэрэг буюу 27.4 хувиар өссөн байна.

Хүн худалдаалах 8 хэргийн 4 буюу 50.0 хувь нь Улаанбаатар хотод гарсан байна. 2014 онд энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 77.8 хувь байгаа нь өмнөх оныхоос 11.1 пунктээр өссөн байна. Хүн худалдаалах гэмт хэрэг өмнөх оныхоос 2 буюу 20 хувиар буурсан байна.

Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 2014 онд 397 болж, өмнөх оныхоос 28 хэрэг буюу 6.6 хувиар буурсан байна. Энэ төрлийн хэргийн 75.6 хувийг эзэлж байгаа хүчингийн хэрэг 2014 онд 300 бүртгэгдэж, өмнөх оныхоос 44 хэрэг буюу 12.8 хувиар буурч, хүүхэд хаях, төөрүүлэх гэмт хэрэг 18 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 4 хэрэг буюу 28.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүүхэд хаях, төөрүүлэх 18 хэрэг бүртгэгдсэн нь бүгд Улаанбаатар хотод бүртгэгджээ. Дүүргүүдээс Баянгол дүүрэг(9)-т хамгийн олон хүүхэд хаях, төөрүүлэх хэрэг гарсан байна.

2014 онд үйлдэгдсэн гэмт хэргийн 6686 буюу 24.5 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг байгаа нь өмнөх оныхоос 280 хэрэг буюу 4.4 хувиар өсөв. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оныхоос өсөхөд Төв(111.6), Хэнтий (41.5), Баянхонгор(27.4), Ховд(25.3), Өмнөговь(16.5), Хөвсгөл(15.0), Сэлэнгэ(14.7), Орхон(12.2), Увс(11.9) хувиар аймгуудад өссөн голлон нөлөөлжээ.

2014 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 76.8 хувь нь ажлын өдөр, 23.2 хувь нь амралтын өдөр үйлдэгджээ. Нийт гэмт хэргийн 17.0 хувь нь даваа гарагт үйлдэгдсэн бөгөөд үүний 66.6 хувь нь нийслэлд, 33.4 хувь нь аймгуудад ногдож байна.

2014 онд бүртгэгдсэн гэмт хэргийн зонхилох хэсэг нь 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн байгаа бөгөөд энэ дүр зураг нийслэл, аймагт ижил байна. Улсын хэмжээгээр бүртгэгдсэн гэмт хэргийн 21.1 хувь нь 06-14 цагт, 26.8 хувь нь 14-19 цагт, 16.2 хувь нь 19-22 цагт, 35.9 хувь нь 22-06 цагийн хооронд үйлдэгджээ.

Хэрэгт холбогдсон нийт сэжигтэн, яллагдагчдын тоо 2014 онд 23.7 мянган хүн болж, өмнөх оныхоос 1451 хүн буюу 6.5 хувиар өссөн байна. Гэмт хэрэгт холбогдогчдын 4.0 хувь нь өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүс байгаа бөгөөд тэдгээрийн эзлэх хувь өмнөх оныхоос 0.4 пунктээр буурчээ.

Гэмт хэргийн улмаас 2014 онд нийт 27.5 мянган иргэн, 118 байгууллага хохирсон нь 2013 оныхоос хохирогч иргэдийн тоо 2460 хүнээр нэмэгдэж, харин хохирогч байгууллагын тоо 39-өөр буурчээ. Гэмт хэргийн улмаас хохирсон эмэгтэйчүүдийн тоо 10.9 мянга болж, өмнөх оныхоос 1064 хүнээр өссөн байна.

2013 оны байдлаар Монгол Улсын 10 000 хүн тутмаас 85 хүн гэмт хэргийн хохирогч болсон бол 2014 онд 93 болж, өмнөх оныхоос 8 буюу 9.4 хувиар нэмэгдсэн байна. Харин 2013 онд 10000 хүн тутмын 35 нь эмэгтэй хохирогч, 5 нь 18 хүртэлх насны хохирогч хүүхэд байсан бол 2014 онд 10000 хүн тутмаас 36 эмэгтэй, 5 нь 18 хүртэлх насны хохирогч хүүхэд болж, 10000 хүн тутамд ногдох эмэгтэй хохирогч 1-ээр өсч, 18 хүртэлх насны хүүхдийн тоо өмнөх оны түвшинд байна. Хохирогчдын 30.1 хувийг нь ажилгүй иргэд эзэлж байгаа нь 2013 оныхоос 296 хүн буюу 1.7 пунктээр өсчээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэгдэх явдал 2014 онд эрс нэмэгдэж, 1076 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 658 хэрэг буюу 2.6 дахин өссөн байна. Энэ нь нэг талаас иргэдийн Цагдаагийн байгууллагад үйлдэгдсэн хэргийг бүртгүүлэх явдал сайжирсан байх талтай боловч нөгөөтэйгүүр гэр бүлийн хүчирхийлэл нийгэмд газар авч, өсч байгаагийн илэрхийлэл юм.

2014 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 1106 хүн хохирсон нь 2013 оныхоос 787 буюу 3.5 дахин нэмэгдэв. Эдгээр хүмүүсийн 83.6 хувь нь бие махбод, 24.2 хувь нь эдийн засгийн хүчирхийлэлд өртжээ. Гэр бүлийн хүчирхийллээс хохирсон хүмүүсийн 56.8 хувийг эхнэр нь, 11.4 хувийг хамтран амьдрагч нь, 3.4 хувийг төрсөн хүүхэд нь, 1.4 хувийг дагавар хүүхэд нь эзэлж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэдийн дийлэнх нь Улаанбаатар хотод байна. 2014 онд Хөвсгөл(48), Орхон(43), Увс(37), Архангай(35), Сэлэнгэ(34), Баян-Өлгий(33) аймгаас хамгийн олон иргэн гэр бүлийн хүчирхийлэлд автсан байна. Дүүргүүдээс Баянзүрх, Баянгол дүүргүүдэд гэр бүлийн хүчирхийлэл хамгийн их гарсан байна.

Гэмт хэргийн улмаас 2014 онд 27.5 мянган иргэн хохирсны 1.1 мянга буюу 3.9 хувь нь нас барж, 11.3 мянга буюу 41.1 хувь нь гэмтсэн байна. Хохирогч иргэдийн тоо өмнөх оныхоос 9.8 хувиар, нас барсан иргэдийн тоо 13.6 хувь, гэмтсэн иргэдийн тоо 15.1 хувиар нэмэгджээ.

Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирол 2014 онд 148.3 тэрбум төг болж, өмнөх оныхоос 10.7 тэрбум төг буюу 6.7 хувиар буурч, харин нөхөн төлүүлэлт 43.7 тэрбум төг болж, 67.6 тэрбум төг буюу 60.8 хувиар буурсан байна.

Шүүхээр шийдвэрлүүлэхээр 2014 онд 7603 хэрэг ирсний 6375 буюу 83.8 хувь нь шийдвэрлэгдэж, 694 буюу 9.1 хувь нь мөрдөн байцаалтанд буцаж, 18 буюу 0.2 хувь нь хэрэг бүртгэлд буцаж, 23 буюу 0.3 хувь нь харьяаллын дагуу шилжсэнээр 493 буюу 6.5 хувь нь шийдвэрлэгдээгүй үлдсэн байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг өмнөх оныхоос 1.3 пункт, тайлант хугацааны үлдэгдэл хэрэг 1.3 пунктээр буурч, харин мөрдөн байцаалтанд буцсан хэрэг 2.3 пунктээр өссөн байна.

2014 оны байдлаар шүүхээр 6375 хэрэг шийдвэрлэгдэж, 8178 хүн ял шийтгүүлж, 78.2 тэрбум төгрөгийн хохирол учирч, 1.5 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Хөдөлмөрийн маргаан 2013 оныхоос 297 буюу 27.5 хувиар нэмэгдэхэд цалин хөлсний маргаан 269–аар, ажлаас үндэслэлгүй халсан шалтгаан 17-оор өссөн нь голлон нөлөөлжээ.

2014 онд Шүүхээр 18859 захиргааны зөрчил шийдвэрлэгдсний 18611 буюу 98.7 хувьд нь захиргааны арга хэмжээ авагдаж, 248 буюу 1.3 хувь нь арга хэмжээ авахаас татгалзаж буцсан зөрчил байна. Захиргааны арга хэмжээ авагдсан зөрчлийн тоо өмнөх оныхоос 0.2 пунктээр өсч, харин арга хэмжээ авахаас татгалзсан зөрчил 0.2 пунктээр буурчээ.

2014 онд 119.0 мянган хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оныхоос 4.5 мянга буюу 3.8 хувиар буурсан байна. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж эрүүлжүүлэгдсэн хүний 64.9 мянга буюу 54.6 хувь нь нийслэлд, 50.7 мянга буюу 42.6 хувь нь аймгуудад, 3.3 буюу 2.8 хувь нь төмөр замд эрүүлжүүлэгдэж, үйлчилгээний төлбөрт нийт 413.2 сая төгрөгийг төлсөн байна.

Жил бүр нийт эрүүлжүүлэгдсэн иргэдийн 50-иас дээш хувь нь Улаанбаатар хотод эрүүлжүүлэгддэг байна. Дүүргүүдээс 2014 онд Баянзүрх (14722), Сонгинохайрхан (12831)-д хамгийн олон хүн эрүүлжүүлэгдсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 2014 онд 840.5 тэрбум төгрөгийн хохирол барагдуулахаас 330.0 тэрбум төгрөгийн хохирлыг барагдуулсан байна. Үүний 7.0 тэрбум төг буюу 2.1 хувь эрүүгийн хэргийн, 270.2 тэрбум төг буюу 81.8 хувь нь иргэний хэргийн, 55.7 тэрбум төг буюу 16.9 хувь нь бусад хэргийн нөхөн төлүүлэлт байна.

## 8. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- 2014 онд гэмт хэргийн улмаас нас барсан хүмүүсийн 46.7 хувь нь ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алдсан нь нийгэмд асар их хор хохирлыг учруулж байна. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн тоо 2014 онд буурсан хэдий ч энэ төрлийн гэмт хэргийн 73.3 хувийг эзэлж буй зам тээврийн ослын хэрэг өмнөх оныхоос 151 буюу 10.6 хувиар өссөн байна. Иймээс зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд жолоочийн ур чадварыг дээшлүүлэх, нийт иргэдэд замын хөдөлгөөнд зүй зохистой оролцох соёл, дадал эзэмшүүлэх, замын чанар, гэрэлтүүлэг, жолооны сургалтын чанарыг сайжруулах, орон нутаг, гэр хорооллын замыг стандартад нийцүүлэх ажлуудыг хийх шаардлагатай байна.

- Гэмт хэрэг үйлдэж байгаа хүмүүсийн 57.0 орчим хувь нь ажилгүй иргэд болон оюутан, сурагчид байгаагаас харахад ажлын байрыг шинээр буй болгох хэрэгцээ шаардлага байсаар байна.
- Хүн худалдаалах гэмт хэрэг 2014 онд 8 бүртгэгдэж өмнөх оныхоос буурсан хэдий ч, 8 хэргийн 4 Улаанбаатар хотод гарсан байна. Иймээс охид, эмэгтэйчүүд, түүний дотор бага насны охидыг бэлгийн мөлжлөгт өртөхөөс хамгаалах, бага насны хүүхэд, эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлэх, албадан хөдөлмөр хийлгэх, хүчирхийлэх явдалтай эрчимтэй тэмцэх, далд хэлбэрээр хүүхэд, эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлж буй хэсэг бүлэг, хүний наймаа эрхлэгчдийг илрүүлж таслан зогсоох чиглэлд анхаарлаа хандуулж ажиллах хэрэгтэй байна.
- Хүүхэд хаях, төөрүүлэх гэмт хэрэг 2014 онд улсын хэмжээгээр 18 бүртгэгдсэн нь бүгд Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Иймд хүүхдээ хаяж, төөрүүлж буй эцэг эхэд ноогдуулах хариуцлагыг хуульчлах, үүрэг хариуцлагыг ухамсарлуулах, хариуцлага тооцох арга механизмыг улам боловсронгуй болгох нь зүйтэй байна.
- 2014 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оныхоос 2.6 дахин нэмэгдсэн нь энэ төрлийн гэмт хэргийг бууруулах талаар авах арга хэмжээг яаралтай эрчимжүүлэх, хүчирхийлэгчдэд хариуцлага хүлээлгэдэг хууль эрх зүйн орчинг нэн даруй буй болгох хэрэгтэй байна.
- Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийг хамгаалах, учирсан хохирлыг барагдуулах, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд үйлчлэх байр, нийгмийн бусад тусламжийн үйлчилгээг сайжруулж шинэ шатанд гаргах хэрэгцээ, шаардлага байсаар байна.
- Одоогоор Монгол Улсад гэмт хэргийн хохирогчийн зөвхөн эд материалын хохирлын тодорхой хэсгийг нөхөн төлүүлж байгаа бөгөөд цаашид бусад хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх тодорхой хөтөлбөр, төсөл боловсруулан ажиллах хэрэгтэй байна.
- Бусдын бие махбодид гэмтэл учруулах болон бусдын эд хөрөнгийг хулгайлах, хувийн өмчийг хулгайлах, эд зүйлсийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийн гаралт ч нэмэгдсээр байгаад анхаарч ажиллууштай байна.
- Гэмт хэргийн статистикийн мэдээллийн чанар, уялдаа холбоог сайжруулах, хууль эрх зүйн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сантай болоход цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна.

